



Батлан хамгаалахын сайд асан Д.ДОРЛИГЖАВТАЙ ярилцлаа.

**Манай улс зах зээлийн нийгэмд шилжээд удаагүй, эдийн засгийн нөхцөл байдал хүнд цаг үед та Батлан хамгаалахын сайдын үүрэгт ажлыг хүлээж авч байсан. Тамгаа гардаг аваад ажлаа юунаас эхэлж байв?**

-Ардчилсан нам 1996 оны сонгуульд ялж бусад намтай эвсэл байгуулж, Засгийн эрхийг авч байлаа. Тэгээд шинээр байгуулагдсан Засгийн газар цэргийн шинэчлэлийн бодлогыг эхлүүлэх хэрэгтэй гэж үзсэн учир түүхэндээ анх удаа Батлан хамгаалахын сайдаар энгийн хүн томилохоор болсон. Ингээд хэнийг томилж вэ гэж нэлээд яригдаж байгаад цэргийн хэргийн зохих мэдлэгтэй, Шадар сайдаар ажиллаж байсан туршлагатай гэж үзэн намайг томилж байсан юм.

Монголын Ардын Армид цэргийн шинэчлэлийг эхлүүлэх нь миний гол ажил байсан. Энэ тухай ярихын өмнө тухайн үеийн Зэвсэгт хүчин ямар байсан талаар дурдах нь зүйтэй. Монголын Ардын Арми нь үндсэндээ Зөвлөлтийн армитай хамтран дайсны эсрэг тэмцэл явуулах гол концепттой байлаа. Хэргийн сургуулиудын төлөвлөлт нь хориглолт, давшилтын маш том масштабд явагддаг байв. Гэтэл 1989 оны 5 дугаар сард ЗХУ манай улсаас цэргээ гаргахаар шийдвэрлэлээ. Цэрэг-улс төрийн холбоотон байсан Орос улс гэнэт ямар ч тохиролцоо хийлгүй ийм шийдвэр гаргасан нь тухайн үеийн хоёр улсын коммунист намын удирдлагад ч гэнэтийн зүйл болсон. Зарим хүмүүс Оросын цэргийг Ардчилсан холбооныхон хөөгөөд гаргахихсан гэж их ярьдаг. Үнэн хэрэгтэй тийм биш юм. Ердөө л Хятадтай харилцаа холбоогоо сайжруулах гэсэн Оросын алхам байсныг дараа нь бид мэдсэн.

1990 оны Ардчилсан хувьсгалтай давхцаад Зөвлөлтийн цэрэг манай орноос гарч дууссан. Ингээд Монголын Зэвсэгт хүчин яах вэ гэсэн асуулт урган гарч ирлээ. Тэгээд зогсохгүй шинэ Үндсэн хууль батлагдаж түүндээ "18-26 насны бүх эрчүүд цэргийн алба хаах үүрэгтэй" гээд заачихсан. Гэтэл тэр үед цэргийн насны эрчүүдийг, одоо ч мөн ялгаагүй бүгдийг хаалгана гэвэл улсад тийм эдийн засгийн боломж, Зэвсэгт хүчинд тийм багтаамж ч байхгүй, тийм шаардлага ч алга байлаа. Тиймээс Үндсэн хуулийн энэ заалтыг хоосон заалт болгочихгүйн тулд яаж хэрэгжүүлэх вэ гэсэн асуудал миний хувьд хамгийн эхэнд тавигдсан. Тиймээс цаг үетэйгээ уялдсан эрх зүйн зохицуулалт зайлшгүй хийх ёстой гэж бодсоны дүнд хугацаат цэргийн албыг биеэр хаахаас гадна дүйцүүлэх алба, цэргийн гэрээт алба, мөнгөн хэлбэрээр гэсэн төрөл байхаар эрх зүйн шийдлийг бий болгосон.

Дүйцүүлэх алба нь амьдрал ахуй дорой, цэргийн алба хаах боломжгүй залуусыг орон нутгийн цэргийн штабуудаар дамжуулан орон нутгийн төрийн захиргааны байгууллагын мэдэлд жилийн хугацаанд тодорхой үүрэг гүйцэтгүүлэх юм. Тухайн үед хугацаат цэрэг нэг жил болсонтой холбоотой арми бага мэргэжилтнүүдээр дутагдаад байв. Үүний нөхөн хангалтыг эхлүүлэх, цаашдаа мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчинтэй болох эхлэлийг тавих зэрэг олон ач холбогдлыг бодсоны үүднээс цэргийн гэрээт албыг бий болгосон. Хуучнаар бол түрүүчийн албыг дахин сэргээсэн гэсэн үг. Энэ алба ялангуяа Хилийн цэрэгт их зохидог. Үндсэн хуулийн заалтыг хангахын тулд бид ингэж эрх зүйн зохицуулалтуудыг хийж байлаа.

**Сайдаар ажиллах хугацаандаа хийсэн хамгийн том ажил юу байсан бэ?**

-Эргээд бодоход бидний хийсэн ажил бүгд л Зэвсэгт хүчний цаашдын хөгжилд чухал түлхэц болсон ажлууд байжээ гэж бодогддог. Миний үед арми хэдэн зэвсэг техникээ хадгалалтад тавьчихсан, сургалт бэлтгэл хийх төсөвгүй, залуу цэргийн алба хаагчид олноороо бизнес эрхлэхээр армис гардаг "моод"-той болчихсон. Өөрөөр хэлбэл, бие бүрэлдэхүүний сургалт дадлага, хангамж зэргээс гадна цаашдын цэргийн номлолоо яаж авч явах эсэх нь тодорхойгүй тийм цаг үе байлаа. Тиймээс бид эхлээд эрх зүйн орчныг өөрчлөх зайлшгүй шаардлагатай тулгарсан. Иймд БХЯ, ЗХЕШ цугтаа байсныг салгасан. ЗХЕШ бол цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, БХЯ нь төрийн захиргааны төв байгууллага хэмээн үзэж үйл ажиллагааг нь зааглаж, тусдаа хоёр субъект байхаар хуульчилсан.

Энд нэг зүйлийг хэлэхэд социализмын үед армийн үйл ажиллагааг баталгаажуулж, зохицуулсан тусдаа хууль байгаагүй. Тиймээс Батлан хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжуудыг салбарлуулах үүднээс Цэргийн шинэчлэлийн багц хуулийг эхний ээлжид найман төсөлтэйгөөр боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан. Тэдгээр хуулиар Зэвсэгт хүчний анги, байгууллагууд тайван цагт иргэний хамгаалалтад туслах, хөрш зэргэлдээ улсад үймээн самуун гарах үед хэрхэх, дүрвэгсэд хил зөрчих, тодорхой зэвсэгт бүлэглэлүүд нутгийн гүнд нэвтрэх, улс орноо харийн дайснаас хамгаалах зэрэг олон эрх зүйн зохицуулалтыг хийж, бичиг баримтууд гаргасан.

Мөн олон улсад энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх зорилтыг шинээр оруулж ирсэн. Тэр үедээ энэ нь асар их хэрүүл маргаан дагуулж, үүнээсээ болж мань мэт нь их ч доромжлуулсан. "Сэрүүн зүүдэлж байна", "Юу ч мэдэхгүй байж их юманд санаархлаа" гээд яриад байвал хөвөрч өгнө. Нэгэнт зорилт тавьсан учир ажлаа хийх ёстой. Ингээд энхийг сахиулах ажиллагаанд

оролцох бүрэлдэхүүнийг тусад нь бэлдэхийн тулд Элитийн батальон гэгчийг байгуулах шийдвэр гаргаж, сургалт бэлтгэл, галт хэрэгслийн тооцоо, нормоосоо эхлээд бүх зүйлээрээ бусад ангиудаасаа онцгой байлгахар шийдвэр гаргаж байлаа.

Мөн бидний хийсэн нэг зүйл бол Зөвлөлтийн цэргийн номлолтой уялдсан Монголын Ардын Армийн хүч бүрэлдэхүүний байрлалыг өөрсдийнхөө шинэ нөхцөл, цаг үед тааруулж, шинээр эмхлэн зохион байгуулж, анги, байгууллага шилжүүлэх,

-Гарцаагүй төсөв мөнгөний асуудал хүнд байсан. Уг зовлонгоо УИХ, Засгийн газарт уламжлаад хүлээж аваагүй, үнэндээ тухайн үеийн улсын эдийн засгийн чадамж сул, хүнд байсан. Жилийн инфляц 60-70 хувьтай байсан гээд бод доо. Одоо 8-9 хувь л байгаа биз дээ. Тэгж бодохоор юмны үнэ ямар хурдан нэмэгдэж байсныг төвөггүй ойлгож болно. Хэдий нөхцөл байдал тийм байсан ч хийх гэж байгаа ажлаа зогсоолтой нь биш, ямартай ч хуучин төсвөө хасуулахгүй, төсвийн дотоод

## Д.Дорлигжав: ХОЁР ЖИЛИЙН ХУГАЦААНД БОСОХ, СУУХ ЗАВГҮЙ АЖИЛЛАЖЭЭ



тохижуулах том ажлыг өрнүүлсэн явдал юм. Тухайлбал, манай орны хамгийн чухал чиглэл болох Дорнод аймагт 030 дугаар Барилгын цэргийн батальоноос өөр Зэвсэгт хүчний анги байгаагүй учир Зүүнбаянгаас Чойбалсан хүртэл хороог бүтнээр нь нүүлгэн шилжүүлэх урт маршийн цувааг хийж байлаа. Энэ бол орчин цагийн Зэвсэгт хүчний түүхэнд хамгийн томд тооцогдох маршийн цуваа байсан гэж тухайн үеийн цэргийн мэргэжилтнүүд хэлж байсныг санаж байна.

**Батлан хамгаалахын салбарыг гадаад харилцаагүйгээр төсөөлшгүй болох нь хил ирэх бүр улам тод харагдаж байна. Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаа тухайн үед ямар түвшинд байсан бэ?**

-Аль ч улстай дайснаас үйл ажиллагаа явуулахгүй, цэргийн аль нэг эвсэл, холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэртээ цөмийн зэвсэг байрлуулахгүй, гаднын цэргийн хүчийг нутгаараа дамжин өнгөрүүлэхгүй зэрэг санаачилгыг НҮБ-д Монгол Улс тавьсан. Үүний хариуд НҮБ-аас Монгол Улсын гадаад бодлогыг соёрхож, аюулгүй байдлыг нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын таван үед баталгаажуулсан том үйл явдал тэр үед болж байсан. Үүнийг дагаад армийн цэргийн номлол өөрчлөгдөх ёстой болж, Төрийн цэргийн бодлого баримт бичгийг гаргасан.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцааны хувьд яг үнэндээ тэр үед манай офицерууд Зөвлөлтийн бүрэлдэхүүнд багтаж байсан орнуудаас өөр орны хүнтэй дуугарч чаддаггүй байсан. Угаасаа цэргийн сургуульд байхаас нь тэгээд хүмүүжүүлчихсэн. Тэгээд ч өөр улсын хүнтэй уулзалал тагнуулын байгууллагын үйл ажиллагааны хараанд өртдөгөөс эхлээд тун амаргүй нөхцөл утдаг байсан. Энэ байдлыг засаж шинэчлэхийн тулд бид гадаад харилцаагаа өргөжүүлэх ажлаа эрчимжүүлсэн. Олон улсын цэргийн удирдлагууд, батлан хамгаалахын атташе нарыг эх орондоо урьж, цэргийн алба хаагчдаа дэлхийн олон оронд сургаж бэлтгэх бодлого баримтлан ажиллаж байгаагаа уламжилж, хамтарч ажиллах хүсэлтээ тавьдаг байв. Тэд ч бидний хүсэлтийг нааштай хүлээн авч, бодлого шийдвэрийг минь дэмждэг байсан. Түүний хүчинд өнөөдөр би ямар ч хүнтэй уулзсан ам бардам хэлдэг юм, "Аль ч яам, тамгын газар байхгүй өндөр боловсролтой бүрэлдэхүүн зөвхөн БХЯ, ЗХЖШ-т ажиллаж байна" гэж. Энэ бодлого асар хурдан дэмжлэг авч, үйл ажиллагаа болж, олон зуун офицер, ахлагч нар дэлхийд батлан хамгаалах хүчнээрээ тэргүүлдэг улсуудад цэргийн боловсрол эзэмшиж байгаад би үргэлж талархаж явдаг. Ер нь одоо ингээд бодохоор хоёр жилийн дотор босох, суух завгүй ажилласан байна.

**Энэ олон шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх үед улс орны эдийн засаг сайн байгаагүй. Та хэрхэн даван туулж байв?**

зориулалтуудыг шаардлагатай бол хольж солихоо ч Засгийн газарт дуулгасан. Ингээд жилийн батлан хамгаалахын төсвөө аваад анализ хийж үзлээ. Тухайн үед бие бүрэлдэхүүний нөхөн хангалт 74 хувьтай байсан ч 100 хувиар төсвийн цалин ирдэг байсан. Тэгэхээр журмаар хориотой ч тэр 30 орчим хувийн илүү төсвийг аваад өөр зүйлд зарцуулаа. Энэ мэт хэрэггүй эсвэл тэвчиж болох зардлаас гадна маневрлаж болох санхүүгийн ямар зардлууд байна тэднийг дэс дараатай зарцуулж, хүнд үеийг ардаа орхисон.

Нөгөөтэйгүүр урд хилээр зөрчил маш их. Хятадууд хил зөрчин олноороо орж ирэх нь ердийн үзэгдэл болоод байлаа. Хятадад албан ёсны айлчлал хийх үеэрээ тус улсын Батлан хамгаалахын сайдтай цэргийн хамтын ажиллагааны гэрээний төслийг байгуулсны зэрэгцээ урд хил дагуух зөрчлийг арилгахаар тохиролцсон юм. Ингээд хоёр улсын Батлан хамгаалахын сайд нарын тохиролцооноор тэр асуудал жилийн дотор шийдэгдэж, зөрчил гарахаа больсон. Хойд хилээр ч мөн байдал хүнд байлаа. Тува орчмоор буу зэвсэгтэй хүмүүс байнга хил зөрчиж, мал амьтан хулгайлах, иргэдийг дээрэмдэх нь хэрээс хэтэрсэн. Бид ч арга буюу ашиглалтаас гарч, армийн нөөцөд шилжсэн винтов буунуудаас хилийн дагуух малчдад хямд үнээр зарж, шаардлагатай тохиолдолд гал нээж болохыг сануулсан. Түүнчлэн ОХУ-ын БХЯ-нд хүсэлт тавьж албан ёсны айлчлал хийсэн. Тэр үед Батлан хамгаалахын сайдаар хурандаа генерал Игорь Родинов ажилладаг байлаа. Тэр бээр өмнө нь ЗХЖШ-ын Академийн захирал байсан болохоор олон монголчуудыг цэргийн дээд боловсрол эзэмшүүлсэн, ер нь монгол хүнд элэгтэй сайн хүн байсан. Тэр нь ч айлчлалын үед ихэд хэрэг болж хилийн зурвасаа аюулгүй болгохоос эхлээд олон ч ажил амжуулаад авсан маш үр дүнтэй айлчлал болсон доо.

**Ажиллах цаг хугацаандаа шийдвэрлэхэд хамгийн хүнд асуудал юу байсан бэ, хэрхэн шийдвэрлэв?**

-Асуудлыг хүнд гэж харвал жижиг зовлон ч уулын чинээ харагдана. Одоо бодоход тэр нь хүнд, энэ нь амар байсан гээд хэлэх зүйлгүй. Бэрхшээл бүрийг шийдвэрлэхийн төлөө, цэргийн шинэчлэлийн бодлогыг утгаар нь хэрэгжүүлэхийн төлөө бид шаргуу ажилласан. Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд, манай Агаарын цэргийн нөхцөл байдал тун хүнд байсан. Зөвлөлтийн цэргийн том радио станц, локаторуудаас эхлээд нисэхийн анги салбарууд бүгд гараад явчихсан. Тиймээс агаарын довтолгооноос хамгаалах ротуудын бэлэн байдал, техник хэрэгслийн боломжийг тооцож үзээд Монгол Улсынхаа нутаг дэвсгэрт агаарын хилийг манах салбаруудыг байгуулах тушаал гаргасан. Тэр үед агаарын хил байтугай газрын хил ч маргаантай байсан гэж би дээр дурдсан даа. Ер нь бид агаарын довтолгооноос хамгаалахад их анхаарал хандуулсан.

Мөн төрлийн цэрэгт Барилгын цэргийн хороо байсан. Улсын төсвөөс мөнгө аваад байдаг, гэвэл хийлгэх ажил байхгүй. Зах зээлийн зарчмаар ажиллаад өөрсдийгөө санхүүжүүл гэхээр чухал байрлалтай ангийн байр, хашаа, талбайн ихэнхийг хувийн аж ахуй нэгжид зарчихсан. Ийм байдалтай байсан учир яалт үгүй шинэ зохион байгуулалтад шилжүүлэх шаардлагатай тулгарсан. Тэгээд Барилгын цэргийн штабыг Жанжин штабын байранд оруулаад штабын төв байрыг Хилийн цэргийн ерөнхий газрын штабын байр болгож

өөрчилсэн. Тухайн үед Хилийн цэрэг орох оронгүй болчихсон тун хэцүү байдал байлаа шүү дээ.

**Тухайн үед нэг баг болон ажиллаж, гар нийлж байсан хүмүүсээс дурдвал...**

-Армид ирэхэд надад таних хүн бараг л байгаагүй. Таньдгаас ганц хошууч генерал Р.Гаваа агсан байлаа. Намайг сайдаар ирэхэд салбарын удирдлага хүндэтгэлтэйгээр хүлээж авсан. Ажлаа авсны дараа олон жил ажилласан, нас ч залуу гэдгээр нь дэслэгч генерал Ц.Дашзэвэгийг Төрийн нарийн бичгийн даргаар томилсон. Тэр үед Батлан хамгаалахын дэд сайд гэсэн албан тушаал байгаагүй. БХЯ шинэ бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр ажлаа эхлээд миний удирдлагад хошууч генерал С.Баасанхүү, З.Болдбаатар гээд олон сайн цэргийн дарга нар байсан болохоор бодож төлөвлөсөн ажлууд маань хурдан шуурхай, саад тотгор багатай бүтдэг байсан.

**Сайдын албан тушаалаа өгчөөд танд хамгийн түрүүнд юу бодогдсон бэ?**

-Засгийн газар харамсалтай нь улс төрийн шалтгаанаас болоод огцорсон. Мэдээж ажлын амтанд орчихсон тогоотой сүү шиг ид буцаж байсан үедээ ажлаа өгсөн болохоор дуусгаагүй дөнгөж эхлэлийг нь тавьсан ажил их байлаа. Харамсаж байсан нэг зүйл бол цэргийн шинэчлэл дөнгөж гараандаа яаж байсан цаг үе. Өмнө нь тоймлон дурдсан тэдгээр ажлууд бол дөнгөж эхлэл нь гээд бод доо.

**Батлан хамгаалахын сайд байсан хүний хувьд одоогийн Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаатай холбоотой, үүнийг ингээд хийчихвэл гэсэн санаа бий юу?**

-Одоо байгаа зэвсэг техникээ бүгдийг нэг бүрчлэн гаргаж, элэгдэл хорогдлыг нь толгой дараалан үзэж шалгах хэрэгтэй. Цэргийн бага мэргэжилтнүүдийг сайтар бэлтгэхэд анхаарах нь мэргэжлийн чадварлаг Зэвсэгт хүчинтэй болохын гол үндсийн нэг гэж хардаг. Зэвсэглэлд анхаарах цаг нь болсон. Орчин үеийн том зэвсгүүдийг худалдаж авна гэвэл зардал маш өндөр. Тухайлбал, 4+ үеийн орчин үеийн сөнөөгч онгоц гэхэд аеро дром, инженер техникийн бүрэлдэхүүн, шатахуун гээд маш өндөр зардлыг өдөр тутамдаа шаардаж байдаг. Энэ цаг үед Зэвсэгт хүчин тийм их төсөв зардал гаргах боломжгүй. Тэгэхээр ямар зэвсгийг яаж хэрэглэж аюулгүй байдлаа хангах вэ гэдгийг цоо шинээр харах цаг нь болсон.

Байлдааны шинэ нисдэг тэрэг, танк, их буу аваад дайн хийнэ гэхэд энэ том хоёр хөршийн дунд яах ч юм. Түүний оронд авсаархан, хэрэглэхэд хялбар орчин үеийн дэвшилтэт технологи ашигласан шинэ маягийн зэвсэглэлийг эзэмших, боловсруулахад илүү анхаарах хэрэгтэй. Саяхан Карабахын зэвсэгт мөргөлдөөнөөс бид харлаа шүү дээ. Зардал ихтэй том танк, нисэх онгоц, хуягт тээвэрлэгчүүдийг жижигхэн дрон ирээд л жагсаалтаас гаргаж хэрэглэж эхлээд. Иймд дэлхий дахинаа өдрөөс өдөрт өөрчлөгдөн шинэчлэгдэж зэвсэглэлд шингэж байгаа инновацыг сайтар судалж, технологийн дэвшилээ аль нь Монгол орны геополитик, газар зүйн байрлалд тохирох, түүнийг хэрхэн зэвсэгт тэмцэлд ашиглаж болох вэ гэдгийг судалж, энэ талын судалгаа шинжилгээг эрчимжүүлэх ёстой. Орчин үеийн технологийн бидэнд өөр боломж олгож байна.

**Энэ жил тохиож байгаа их ойд зориулаад та юу хэлэх вэ?**

-Эдгээр өдрүүдэд БХЯ байгуулагдсаны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жилийн ой тохиож байна. Улс орныхоо өмнө онцгой үүрэг гүйцэтгэдэг офицер, ахлагч, бэлтгэл чөлөөнд гарсан ахмадуудаа эрүүл энх, ажлын их амжилтыг хүсэн ерөөе. Сургалт бэлтгэлээ аль болох орчин үеийн дэлхийн нөхцөл байдалтай уялдуулж, байнга шинэчлэн сайжруулж, тасралтгүй зохион байгуулж, ямар ч үед эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ мадаггүй биелүүлдэг байхын төлөө өдөр бүр өөрийгөө дайчлаарай гэж цэргийн алба хаагчдадаа "Соёмбо" сониноор уламжлуулан ахмад сайдын хувьд захъя.

Ахмад М.МӨНХЗОРИГ



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

# Ц.Дашзэвэг: САЛБАРЫНХАА БАРАГ БҮХ ХУУЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД ОРОЛЦСОН

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн тэгш дүүрэн ой хаяанд ирлээ. Батлан хамгаалахын тэргүүн дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн цэргийн бодлогын зөвлөхөөр ажиллаж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албыг 1998-2002 онд хашсан чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэгтэй ойрмогхон уулзаж ярилцав.



тодорхойлох, Байлдааны ба дайчилгааны бэлэн байдлыг хангах, Цэргийн нэгтгэл, анги, байгууллагуудыг оновчтой байршуулах, Улс орноо батлан хамгаалахад шаардлагатай материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, Цэрэг, штабын бэлтгэл, жигдрэлтийг хангах гэсэн асуудлууд орж байгаа юм. Дэвшүүлж буй зорилтоос хамаараад яаж өөрчлөх вэ гэдэг нь тодорхойлогдоно хэмээн ярилаа.

Зэвсэгт хүчин олон талт үүрэг гүйцэтгэх болсон талаар түүний үгийг сонсож билээ. Генерал маань аргагүй л том стратегич, батлан хамгаалах тогтолцоо судлаач хүн юм. “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Цэргийн номлол” хоёр баримт бичиг нэг өдөр нэг тогтоолоор батлагдсан юм гээд нэгэн дурсамжийг хуваалцлаа.

Гадаад харилцааны яаманд “Гадаад бодлогын үзэл баримтлал” баримт бичиг батлагдсаны 20 жилийн ойн арга хэмжээ болов. Энэ хурал дээр энхийг сахиулах ажиллагааны эцэг гэх хүмүүс тодроод би эхлүүлсэн, би санаачилсан гэсэн яриа гарлаа. Би тэр хурал дээр үг авч хэлэхдээ “Төрийн цэргийн бодлогын үндэс”-ээс эшлэл авч хэлж байсан. Тэрхүү баримт бичигт энхийг сахиулах үүрэг гэж орсон. “Ялалт бол зуун эцэгтэй, ялагдал өнчин” гэсэн үг байдаг. Энхийг сахиулах ажиллагаанд сайн яваад нэр хүнд нь өсөөд ирэхлээр “эцэг” тодрох гээд байна шүү дээ. Олон эцэгтэй байх нь аргагүй ээ, гэхдээ эрх зүй нь ингэж гарсан гэдгийг хэлж байсан санагдаж байна. Зэвсэгт хүчний тайван цагийн үүргийг шинэчлэн тогтооходоо НҮБ-ын энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх үүргийг Зэвсэгт хүчинд ногдуулсан гэж өгүүлэв.

Ц.Дашзэвэг генерал төрийн албандаа цэг тавина гээд 2019 онд “Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл” номыг гаргасан гэж ярьсан. Энэ бүтээлд Батлан хамгаалах бодлого, тогтолцоо, Зэвсэгт хүчний байгуулалтыг дээр өгүүлсэн найман асуудал тус бүрээр хөндөж бичжээ. Түүнчлэн Зэвсэгт хүчний удирдлагын тогтолцооны тухай өгүүлсэн байна. Мөн Зэвсэгт хүчний улс төрийн дээд удирдлага, Төрийн захиргааны удирдлага гэж юуг хэлж байгаа, Цэргийн захиргааны болон Мэргэжлийн удирдлагын талаар тодорхойлж бичсэн нь залуу дарга нарт нүдийг нь боогоод тавьсан ч төөрхөөргүй хөтөч болжээ.

Өмнө нь “Цэрэг армийн тухай-2” гэж ном гаргасан. Тэр номыг гаргасан түүх бас сонин. Генералын ангийнхан 10 дугаар анги төгссөний 50 жилийн ойгоо тэмдэглэнэ гээд нэлээд ажил болцгоожээ. Болсон болоогүй дурсамж бичиж, баахан зураг хөрөг бүхий ном гаргана гээд байхаар нь тэр бээр болиулав. Дараа нь ном гаргах гэж байсныг нь болиулчихлаа гэж жаахан шаналсан аж. Тэгээд хуралд тавьсан илтгэл, хэвлэлд өгсөн ярилцлага, нийтлэлүүдээ нэгтгээд ном гаргахыг гэж шийдэв. Ангийнхны уулзалтад 20 гаруй хүн ирэв, бүгдэд нь өгсөн. Тэд ч бөөн баяр болжээ.

Ц.Дашзэвэг генерал сүүлийн 10 жил батлан хамгаалах тогтолцоог судалж байна. Тогтолцоог үндсэндээ бүрдүүлсэн гэж хэлж болно. Харин бэхжүүлж чадаж байна уу, үгүй юу гэдэг өөр асуудал. Батлан хамгаалах тогтолцооны тулгын гурван чулуу гэж “Цэрэг, армийн тухай-1” номдоо тэрээр бичсэн. Хууль тогтоомж гарахаас бүүр өмнө түүний бичиж, ярьж, үглэж, зарим нэг даргыг загнаж, эмэлж явсан асуудлуудаа эмхэтгэж гаргасан байна лээ. “Ах нь сургаж дүү нь сондог” гэдэг үүднээс түүний бичсэн номуудын үнэ цэн хэзээ ч буурахгүй.

Шинэчлэлийн утга учрыг гардан хэрэгжүүлэх бүрэлдэхүүндээ тайлбарла, ойлгуул гэсэн санааг Дашзэвэг генерал ихэд онцолсон. Манайхан энэ талдаа их алдаад байгаа юм. Жишээлбэл, Хууль зүйн сайд асан Х.Тэмүүжин юм сэдсэн, даанч хэрэгжүүлж чадаагүй. Шинэчлэлийг удирдах онол, арга зүй байхгүй учраас тэр. Хууль гаргалаа, тэгээд болно гэж боддог. Гэтэл сурталчилж, ойлгуулж, таниулж, идэвх хөдөлгөөнийг өрнүүлж байх хэрэгжих болохоос биш хий аяндаа биелэхгүй. Цагдаагийн цол албан тушаалын илэрхийлэл гэсэн. Уул нь тийм л дээ. Тэр шинэчлэлээ зөв хийлээ гэж ойлгож байсан. Тэгсэн ч бүтээгүй, буцсан гэв.

Генерал цааш нь Батлан хамгаалах салбарын бараг бүх хууль тогтоомжийг боловсруулаад батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулахад сүүлийн 20 гаруй жил оролцож, өөрийн бодрол, бодол санаагаа нэмэрлэж явсан хүний хувьд өөрийн эрх зүйн үзэл дээр дурдсан номыг бүтээлээ гэсэн. Өөрөөр хэлбэл, тэгсэн шиг байгаа юм гэхгүйгээр, тэгсэн гэж ам бардам хэлж чадах учраас энэ номыг бүтээжээ.

Хорь гаруй жилийн хугацаанд хилийн цэргийн тухай хуульд би оролцоогүй, бусад бүх хуульд оролцсон. Цэрэг, цагдаагийн алба хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн ажлын хэсэгт албан ёсоор ороогүй ч Г.Рагчаа генералыг явуулаад орой нь юу болов гэдгийг сонсож чиглэл өгдөг байсан. Бусад хуулийг боловсруулахад яамны ажлын хэсгийг ахалж эсвэл бүрэлдэхүүнд нь орж ажиллаж байсан тухайгаа дурдав.

Сүүлийн жилүүдэд тэр бээр Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнд ирж нөгөө л “батлан хамгаалах тогтолцоо” руу орсон. Судалгаа хийж, хуулийн төсөл боловсруулаад явав. “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн ажлын хэсгийг ахалсан. Бодлого гараад ирэхлээр дагаад бусад хуулиудад өөрчлөлт орох шаардлага гарлаа. Тэгээд 2016 онд Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хоёр салгаж хууль болгосон. Тэр бүгдэд ажлын хэсэгт орж ажилласан. Өөрөөр хэлбэл, тэтгэвэрт гарсан ч батлан хамгаалахын дараагийн шинэчлэлд бас оролцсон гэсэн үг.

Батлан хамгаалахын сайдын зөвлөх, чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэг гуайтай зөвхөн батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн асуудлаар яриа өрнүүлсэн нь энэ. 1990-ээд оноос хойш өрнөсөн Зэвсэгт хүчний өөрчлөлт шинэчлэлтийн ноён нуруу болж ирсэн түүний хөдөлмөр, зүтгэлийг хэн ч үгүйсгэхгүй биз ээ. Түүний оюуны бядыг өдгөө ч ашигласаар байна.

Хамтын батлан хамгаалах бодлого, номлолтой явж ирсэн, нам төвтэй армийг ардчилсан нийгэмд зохицсон, иргэний хяналт бүхий Зэвсэгт хүчин болгох үйл явцын суурийг тавьсан хүн дээ гээд хэлчихэд алдаа болохгүй байх. Учир нь батлан хамгаалах тогтолцооны бүх хууль эрх зүйн баримт бичгийн хар зураг түүний ширээн дээр төрсөн юм билээ.

1998 онд УИХ-ын 56 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгээр “Цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай Зэвсэгт хүчинтэй байна” гэж тодорхойлсон. Мэргэжлийн чиг баримжаатай гэдэг нь мэргэжлийн цэрэг рүү ойртсон Зэвсэгт хүчнийг бэхжүүлж, хөгжүүлэх зорилт дэвшигдэж байна гэсэн үг л дээ гэснээр бидний яриа эхлэв.

Цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай гэж юуг хэлээд байна гэж лавлахад, Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудлуудыг шинэчлэх тухай юм. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний нөхөн хангалт, сургалт бэлтгэл, бэлэн байдал, удирдлагын тогтолцоог мэргэжлийн армийн чиг хандлага руу ойртуулна.

Зайлшгүй нэг хөтөлбөр байж тэрхүү зорилт хэрэгжих юм байна гэж үзсэн. Тэгээд хөтөлбөрийн төсөл боловсруулах ажил эхлэв. “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2005-2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” гарч хэрэгжсэн. Энэ нь хэдэн Засгийн газар дамжсан хөтөлбөр болчихсон. Хэрэгжих явц нь Засгийн газар хооронд орхигдох байдал үүсэв. 2016 оноос тухайн Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжих хөтөлбөр боловсруулж батлуулсан. Энэ нь их зохимжтой болсон. Үүний тулд “Төрийн цэргийн байгууллагуудын хөгжлийн стратеги-2030” гэж гаргасан. Энэ стратегит тулгуурлаж Засгийн газар бүр өөрийн хөтөлбөрөө боловсруулж хэрэгжүүлж явах юм.

Судлаач хүний хувьд ажиглахад эхний хөтөлбөрт айтгар давилуун зорилтууд дэвшүүлсэн байдаг. Арга ч үгүй байх. Маш богино хугацаанд мэргэжлийн чиг баримжаатай болчихъё гэж бодсон хэрэг. Гэхдээ уг хөтөлбөр үр дүнгээ өгсөн. Ер нь 2015 он гэхэд Зэвсэгт хүчин мэргэжлийн чиг баримжаатай болсон. Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хоёр хөтөлбөр үндсэндээ хэрэгжсэний үр дүн гэж хэлж болно.

1998-2015 оны хооронд мэргэжлийн чиг баримжаатай Зэвсэгт хүчин болох зорилтыг хэрэгжүүлсэн. Тэгээд “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг 2015 онд батлагдсанаас “Мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчин” болох шинэ зорилт дэвшүүлээд байна гэж ярилаа.

Цомхон, чадварлаг Зэвсэгт хүчинтэй болох зорилт хэрхэн хэрэгжсэн талаар түүнээс тодрууллаа. Тэрээр “Монгол Улсын цэргийн номлолын үндэс” баримт бичгээр 1992 онд дэвшүүлсэн зорилт байгаа юм. Өөрөөр хэлбэл, дайчилгааны бараг дэлгэмэл шахуу армийг цомхон, чадварлаг болгоно гэсэн үг. Тэгээд 1998 он гэхэд үндсэндээ цомхотгосон. “Цом” тэдэн он гээд тэр үеийн цэргийнхэн ярьдаг даа. Цомхотгоно гэдэг бол маш хүнд ажил байсан. Гэхдээ үүнийг манай Зэвсэгт хүчин хохирол багатай даван туулсан. Анги, байгууллагыг бүхэлд нь татан буулгахаар тэнд ажиллаж байсан офицер, ахлагч нарын амьдрал хөндөгдөж байгаа юм. Гэхдээ бид энэ ажлыг ухаалаг хийж чадсан гэж боддог.

Цомхотгоолоор халагдаж буй офицер, ахлагч нартаа “Та нар минь амьдралаа бод доо” гэж хэлээд гэр хүртэл өгч байлаа. Шуудхан хэлэхэд, таван ханатай гэрээр хуурч байгаа асуудал л даа. Сүүлд нь хууль гаргаад 18-36 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгодог болсон. Эв зүйг нь олсоор байгаад 1998 он гэхэд үндсэндээ цомхон болгох амаргүй зорилт биелсэн. Ингээд мэргэжлийн чиг баримжаатай болгох зорилт дэвшүүлж, 2015 он гэхэд хэрэгжлээ. Дараагийн шатанд 2016 оноос мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин болох зорилт дэвшүүлээд байна.

Зорилт бүрийг хэрэгжүүлэх арга зам өөр биз гэж асуухад, Ц.Дашзэвэг генерал Зэвсэгт хүчний байгуулалтын асуудлуудыг хөндөнө гэсэн үг хэмээн товч бөгөөд тодорхой хариулсан. Тэрээр цааш нь, Зэвсэгт хүчний байгуулалтын асуудлуудыг өөрчилж, шинэчилж байгаа юм. Найман асуудал бий. Зэвсэгт хүчний байгуулалт, хөгжлийн хандлагыг төлөвлөх, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн дайны байдлын үеийн болон тайван цагийн хоорондын тоо, чанарын харьцаа, төрөл, мэргэжлийн цэргийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог үндэслэлтэй тогтоох, Цэргийн анги, салбаруудыг зориулалт, чиг үүрэгт нь зохицсон зэвсэг, цэргийн техникээр зэвсэглэх, Зэвсэгт хүчнийг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах тогтолцоо, цэргийн алба хаагчдын алба хаах журмыг

Редакцын шууданд


## ЦАХИМ СУРГАЛТАД ОРОЛЦОО

Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулахад чиглэсэн гарын авлагыг танилцуулах сургалтыг энэ сарын 22-нд цахимаар зохион байгууллаа.

Тус сургалтад Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, ахлах мэргэжилтэн Н.Баттөр, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны дарга, хурандаа Т.Мөнхбаяр болон бусад төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүд зэрэг нийт 300 гаруй албан тушаалтан оролцлоо.

Сургалтаар Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, дэд профессор, доктор А.Алтанзул сургалтын гарын авлагын агуулга, ёс зүйн зөвлөлүүд хэрхэн ашиглах аргачлалыг танилцуулж, сэдэв тус тус хамаарах гол ойлголт, тодорхойлолтыг бодит жишээнд тулгуурлан тайлбарласан бол Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Зүмбэрэлхам энэ сургалтаас гарсан саналыг гарын авлагад тусган ойрын хугацаанд хэвлүүлэн төрийн байгууллагуудад хүргүүлнэ гэдгийг онцлов.

## 30 КМ-ИЙН ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ



Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн 2020-2021 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу салбарын жигдрэлтийг хангах хүрээнд офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид тодорхой маршрутын дагуу 30 км-ийн явган марш үйлдсэний зэрэгцээ алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэхээр хэд хэдэн уралдаан зохион байгуулсан юм. Тэдгээр уралдааны нэг болох цасны сумо тэмцээнд эхний байруудад дэд ахлагч А.Энхбаяр, ахлагч Г.Пүрэвням, дэд ахлагч Б.Ууганбаяр нар шалгарлаа.

## ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ХЭРЭГСЛИЙГ ГАРДУУЛАВ



Булган аймгийн Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын шуурхай штабын дарга, хурандаа Ш.Баасандорж коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг дэмжиж Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн хамт олонд тодорхой тооны маск, халуун хэмжигч, гар ариутгагч зэргийг гардуулан өглөө.

Ч.ОЮУНЧИМЭГ

## АЛБАН ХААГЧДЫН АР ГЭРТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ



Улсын хэмжээнд “Covid-19” цар тахлын халдвар эрчимтэй тархаж иргэд эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд буй энэ цаг үед Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн удирдлага, хамт олны санаачилгаар 2020 оны II ээлжээр татагдан ирсэн хоёр хугацаат цэргийн алба хаагчийн ар гэрт тусламжийн гараа сунгаж, хүнсний зүйлсээр дэмжлэг үзүүлэхийн сацуу тэдгээр байлдагчдын ар гэртээ бичсэн захидал, албаа үлгэр жишээчээр хааж буй тухай батламжийг гардуулж өгсөн юм. Ар гэрийн төлөөлөл ангийн удирдлага, хамт олонд хандан хүүгээ цэргийн албаа нэр төртэй, үлгэр жишээчээр хааж байгаад баяртай байгаагаа илэрхийллээ.



## ЗЭВСЭГТ ХҮЧИН

хурандаа Ж.Гантулга гаргаж өгсөн байна. Тэрхүү лавлагаанд "Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр багийн иргэн Лувсангончигийн Тунгалагийн хүсэлтийн дагуу өвөө Лувсанцэрэн Цэвээновын цэрэгт алба хааж байсан тухайд холбогдох баримтуудад шүүн үзэхэд, Цэргийн яамны албан хаагчдын 1931 оны бүртгэлд:

"Ерөнхий штабын 1 дүгээр газрын орчуулагч, Лувсанцэрэн Цэвээнов, нас 47, Улаанбаатар

хамтран оролцсон байна.

Энэхүү хуралд профессор С.Билэгсайханы "Өвөө минь Их Хүрээг гамингаас чөлөөлөлцсөн" гэсэн илтгэлдээ "Хошой чин ван Барон Унгерн Их Хүрээг гамингаас чөлөөлсний 100 жилийн ой тохиож байна. Аливаа улсын нийслэлийг харийнхнаас чөлөөлөх үйл явц түүхэнд нь тод томруунаар үлддэг. Монгол Улсын түүхэнд энэ ой маш чухал, зайлшгүй тэмдэглэх ёстой юм" гэдгийг тодотгоод өөрийн

хил давж Хатанбаатар ван Магсаржавтай нэгдсэн байдаг. Хэсэг хугацаанд Хужирбуланд сургагчаар ажиллаж байтал Автономит засаг унаж, дараа нь Баатар Вангийн зөвлөснөөр эргэн Орос явж, Улаан армид сэлэмт суманг удирдаж явжээ. Дараа нь буцаж ирээд Баатар Вантай хамт Барон Унгерны командад орж, Улаан хад, Чойрын тулаанд оролцож, улмаар Вандановыг цаазлагдсаны дараа баруун

# МОНГОЛЫН ЛУВСАНЦЭРЭН ХЭН

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой айсуу цаг дор мартагдан орхигдсон зарим хүмүүсийнхээ тухайд тодотгон бичих нь хүн чанарын илэрхийлэл, нөгөө талаар өнөөдрийн жаргалант амьдралыг бий болгохын төлөө өвөг дээдэс, цэрэг эрс маань хэрхэн тэмцэж явсныг хойч үедээ мэдүүлэх ёстой билээ. Ийм бодлын үүднээс урьд өмнө нь сонин хэвлэлд төдийлөн бичигдэж байгаагүй, цэл залуухан насандаа учир битүүлэг байдлаар насан эцэслэсэн нэгэн дайчны тухай цухас өгүүлэхийг зорилго. Энэ хүн бол АИХ-ын депутат, УИХ-ын гишүүн асан, Үйлчилгээний гавьяат ажилтан, Монголын Ардчилсан Холбооны дарга асан, "Буриад соёл, өв уламжлалыг хөгжүүлэх сан"-гийн Ерөнхийлөгч С.Билэгсайханы өвөг дээдэс нь болохыг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Монгол Улсад ирж суурьшсан Буриад ястан түүнийг Лувсанцэрэн Цэвээнов гэдэг. Тэр бээр, хуучнаар ЗХУ-ын Буриад улсын нутагт 1885 онд мэндэлжээ. 1985 онд хэвлэгдсэн "Ардын журамт цэргийн дуртгалууд" номд түүний тухай товчхон дурсамж бичигдэн үлджээ. Л.Цэвээновыг 1919 онд Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын Улаан цэргийн Морин хороонд Сумангийн даргын албан тушаал хашиж байхад нь Тройцосавск хотод яаралтай очихыг тушаажээ. Цэргийн хүн хэзээнээс тушаалаар явдаг учраас тэр дороо л мөнөөх хотод хүрэлцэн очиж, Улаан цэргийн нэгэн хороонд алба хаажээ. Нэг жил гаруйн хугацаанд ажиллаж байтал ангийн захирагчийн тушаал гарч, 1921 оны 5 дугаар сард Алтанбулаг хотноо байрлаж байсан МАН-ын Цэргийн штабт ажиллуулахаар илгээжээ. Очоод нэг их удаагүй байхад нь, түүнийг мөн оны 5 дугаар сарын 28-нд Эрхүү хот дахь Цэргийн сургуульд суралцуулахаар явуулсан аж. Эрхүүд очоод нэг сар хэртэй болж байтал тус сургуульд суралцах шаардлагагүй болсон учир Алс Дорнодын Нарийн бичгийн дарга нарын газраас н.Палиск (Васильев)-ийн хамт Монгол Ардын журамт цэрэгт хүчин туслуулж, харгис хулгайч Цагаантны цэрэг болон Хятадын гоминданы цэргийг сөнөөн тонилгох их үйлсэд тохоон томилж явуулсан байна. Тушаал авсан тэр хоёр Эрхүү хотоос гарч Хөвсгөл их далайг захлан Хатгалын харуулын газарт 7 дугаар сарын сүүлч үеэр иржээ. Тэнд байрлаж байсан Улаан цэргийн 227 дугаар хорооны штабт томилолтын бичиг баримтаа шалгуулан хэд хоносон байна. Тийн байхад нь Жалханз хутагтын бие төлөөлөгч тус хорооны удирдлагуудтай уулзахаар ирж, тодорхой зөвшилцөлд хүрснээр 45 дугаар Улаан цэргийн анги хийгээд Л.Цэвээновыг н.Палискийн хамт хүнд, хөнгөн пулемётоор зэвсэглэн Хутагтын хүрээ рүү явуулсан аж.

1921 оны 8 дугаар сарын шинэдээр тус хүрээний газар хүрэлцэн очихтой зэрэгцэн хүрээний өмнө зүгт 40 мод орчим газраас 100-аад цагаантан, баруун зүгт 60 мод орчим газраас мөн 100

гаруй цагаантны цэрэг Жалханзын хүрээ рүү дөхөж яваа тагнуулын мэдээ ирсэн байв. Цэргийн эрдэмд чамгүй боловсорсон Л.Цэвээнов, н.Палиский нар тэр дор нь цагийн байдлыг үнэлж, тэдний өөдөөс сөрөг тагнуулын бүлгийг газар орноо сайн мэддэг нутгийн ардуудын оролцоотой илгээж, бодит мэдээллийг хурдан шуурхай цуглуулсны хүчинд халдан ирэх аюулыг зайлуулж чадсан байна. Жалханз хутагтын хүрээнд Улаан цэрэг ирж байрласныг хэзээний мэдсэн цагаантнууд Хүрээний баруун талаар хойд зүгийг чиглэн ум хумгүй талийн оджээ. Ямар ч байсан түр зуур амсхийх боломж олдсон завшааныг ашиглан тэд Жалханз хутагттай зөвшилцсөний үндсэн дээр ойрын өдрүүдэд 500 морьт цэргийг дайчлан бүрдүүлэхээр тохирч, Л.Цэвээнов цөөн бус улаан цэргийн хамт цагаантныг мөрдөн мөшгөхөөр морджээ. Цагаантнууд нутгийн ардуудыг тонон дээрэмдэж, уналга морьдоо цаг ямагт сольж явсан болохоор тэдний морьд сульдаж Жалханзын хүрээндээ буцажирэхэд 400 гаруй морьт цэрэг хэзээний бүрдсэн байв. Тэднийг хорооны системд хуваарилж, цэргийн анхан шатны бэлтгэл сургуулилт хийж байтал н.Палискийг Эрхүү хотноо эгүүлэн татсан учир 400 гаруй морьт цэргийг захирах үүрэг түүнд оногджээ. Хамгийн баярлууштай нь, яг энэ үеэр Хатгал харуулын 227 дугаар хорооны штабаас 200 орчим винтовыг тус бүр 100 сумны хамт явуулсан нь шинээр эмхлэгдсэн тэдэнд алтнаас ч илүү үнэтэй байв. Мөн Жалханз хутагт 31 винтовыг сумны хамт хандивласан учир нийтдээ 200 гаруй цэрэг нь буу зэвсэгтэй болж, цэрэг хүний төрхөндөө орж амжив. Энэ үеэр Барон Унгерн Ардын журамт цэрэг болон Зөвлөлтийн Улаан армийн цэрэгт цохигдон, Сэлэнгэ мөрнийг арлан баруун тийш түрэгдэн яваа мэдээ ирж, улмаар Хатгал харуулын тусгай ангийн захирагчийн тушаалаар Барон Унгерны цохигдсон цэрэгтэй тосон байлдахаар өвч бүрэн зэвсэглэсэн 200 гаруй цэргийн хамт Дархадын нутаг хүртэл яваад тааралдсангүй. Хатгал харуулын тусгай хороо ч мөн дайнд мордсон байв. Ийнхүү тулалдах дайсан нь нэгэнт мөхлийн ирмэгт очсон учраас цэргийнхээ хагасыг Мөрөн, Бүрэнд орхиод цөөвтөр цэрэгтэй Жалханзын хүрээндээ буцаж очжээ. Тэнд хамгаалах үүрэгтэйгээр хэсэг хугацаанд сууж байтал Цагаантны оргодол цэрэг бүр мөсөн утсан учир Хатгал харуулын тусгай ангидаа буцаж очсон байна.

Ийм л нэг богинохон түүх намтраа үлдээгээд, цэл залуугаараа тэнгэрийн орныг зорьсон Лувсанцэрэн Цэвээновт холбогдох Архивын баримт сэлт байгаа эсэхийг хүссэн өргөдлийг Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр багийн иргэн Лувсангончигийн Тунгалаг БХЯ-ны харьяа Батлан Хамгаалахын Төв Архивд гаргасны дагуу, 000001373 дугаартай Архивын лавлагааг 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөр огноолон тус Архивын эрдэм шинжилгээний ажилтан, дэд

хотын харьяат, гишүүн бус, идэвхтэй сайн".

"Улаан одон" сонины 1933 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 24 дүгээрт нийтлэгдсэн "Зүтгэлтэй нөхөр аргагүй өвчнөөс болж нас барав" гэсэн баримтад:

"Эдүгээ Ерөнхий штабын газар алба хааж байсан улаан партизан, нөхөр Цэвээновын бие 3 дугаар сарын 11-ний шөнийн 2 цагт гэнэт нас нэгчсэн бөгөөд энэхүү нөхөр Цэвээнов болбоос Монгол Ардын Хувьсгалт Улаан цэргийн албаныг 11 жил илүү болтол туйлын идэвхтэй бөгөөд, ялангуяа Монголын дарга нарыг сургах талаар онц зүтгэж явсны дээр ер ноогдсон ажилдаа туйлын идэвхтэй, шударга бөгөөд дарга нарын тушаал, зааврыг ер зөрчиж явсангүй хийгээд цаг ямагт үнэн шударгыг илэрхийлэн явсаар сая өөрийн биед гэнэт өвчин тохиолдож, эмчлүүлэн сувилуулахын амжил болсонгүй бие баржээ. Иймд энэхүү нөхрийн тийнхүү зүтгэлийг илэрхийлж, зүтгэлт нөхрөө алдсанд гашуудав.

өвөө Лувсанцэрэн Цэвээновын талаар нэлээд дэлгэрэнгүй баримт өгүүлжээ. Тэр бээр, ОХУ-ын Шинжлэх Ухааны академийн Дорно дахины /Улаан-Үдийн/ хүрээлэнд "История 1000 солдат" гэсэн түүхэн баримт "Маш нууц" гэсэн тэмдэглэлтэй хадгалагддаг. Энэ нь "Казачий полк", "Буриадын дивизон" гэж байнга яригддаг цэргүүдийн тухай болов уу?

Тэгвэл "Буриадын дивизон", "Казачий полк"-ын толгойлогч нь хэн байв? Нэг хүн байв уу эсвэл хэд хэдэн хүн байв уу? Энэ бүрэлдэхүүн нь Ардын журамт цэрэг, Зөвлөлтийн Улаан цэрэгтэй эвсэж Гамингийн цэргийг буулт хийхэд хүргэв үү гэх мэт асуулт судлагдахуунаа хүлээсээр ...

Ялангуяа, Нийслэл хүрээнд байрлаж байсан 15000 хүнтэй Хятадын хар цэргийг, 2600 хүний бүрэлдэхүүнтэй Бароны цэрэг хэрхэн ямар стратеги, тактикаар ялсан байх вэ? Дараа нь Резухин генералын 7000 гаминтай байлдсан Улаан хадын, Барон Унгерны удирдан 5000 гаминтай байлдсан

хязгаарын байлдаанд идэвхтэй оролцсон байна. Партизан Лувсанравдангийн Мягмарын дуртгалд өвөөгийн маань тухай тодорхой баримттай мэдээлэл бий. Тухайлбал, Л.Мягмар хошуу ноёнтойгоо муудалцан хар гэрт хоригдох болоод оргон явж байтал Эрхүүгээс явж буй Оросын цэргийн дарга нар бүхий 50 гаруй цэрэгтэй тааралдахад, Буриад Цэвээнов гэдэг өндөр офицер Ардын журамт цэрэгт хэрхэн элсэх, хаашаа явах, хэнтэй уулзах тухай түүнд зөвлөж, Жалханзын хүрээ хүртэл газарчлуулаад, дараа нь Хатанбаатар Магсаржавын бичиг, мөн бидний чухал бичгийг авч Мэргэн гүний нутаг, Рашаантын "Олон нуур" гэдэг газар хуарагнаж байсан Х.Чойбалсан, Шетинкин нарт маш нууцаар хүргэсүгэй гэж гуйв... " гэх зэргээр ярьсан нь дурсамж болон үлдсэн байна.

1920 оны намар Халхын ноёдын урвалтаар Автономит засаг унаад бүтэн нэг жил өнгөрчихсөн, Богд гэгээнийг бариад хорьчихсон, нөлөө бүхий



Л.Цэвээнов гэргий н.Долсмаагийн хамт

Улаан цэрэг" бичигдсэн баримтууд байна.

Жич: "Ардын журамт цэргийн дуртгалууд", УБ хот, 1969 он номд нийтлэгдсэн Л.Цэвээновын дуртгалыг хуулбарлан хавсаргав" гэсэн лавлагаа гаргаж өгчээ.

Харин энэ оны 2 дугаар сарын 4-нд "Монголын түүхэн дэх Барон Р.Ф.Фон Унгерн Штернберг" олон улсын эрдэм шинжилгээний цахим хурал болсон нь олны анхаарлын төвд хүрээд байна. Уг хурлын ерөнхий зохион байгуулагчаар ШУА-ийн Олон улсын хүрээлэн ажиллаж, Ерөнхийлөгчийн Тамгын Газар, "Буриад соёл, өв уламжлалыг хөгжүүлэх сан"

Чойрын тулаан зэргийг нийтийн хүртээл болгох хэрэгтэй. Түүхэн үйл явдалд мэдээж оролцогч этгээдүүд голлох үүрэг гүйцэтгэдэг.

Миний өвөө Лувсанцэрэн Цэвээнов нь "Казачий полк"-ын нэг гол төлөөлөгч байсны хувьд онцлон бичмээр байна. Тухайлбал, 1885 онд төрсөн өвөөг маань 1933 онд гэртээ оройн хоолоо идээд сууж байхад нь гэрийн нь гаднаас жадаар сүлбэж алжаа. Миний өвөө бол Оросын Цагаан хааны үе дамжсан офицер, "Саган сагда" гэдэг Буриадын казакуудын отрядад алба хашиж байсан. Тэр бээр 1919 онд одоогийн Хөвсгөл аймгийн Хатгал сумын нутгаар

эх орончдыг шоронд хорьчихсон, ер нь монголчууд нутагтаа амьдрахад хэцүү болчихсон хүнд цаг үе байжээ. Богд хаан энэ бүхнийг тун сайн мэдээр, нөхцөл байдлаас гарахын тулд Барон Унгерныг урьжээ. Тэгээд Богд хаан бээр, Цэцэн Хан, Түшээт Ханг "Бароныг угтан ав" хэмээн зарлиг буулгасны дагуу тэднийг төлөөлж Түшээт Хан аймгийн Дархан чин Вангийн хошууны тэргүүн зэрэг тайж Лувсанцэвээн нарыг угтуулсан бөгөөд Хатанбаатар Вангийн зараалаар миний өвөө Лувсанцэрэн орчуулагчаар дагалдан явжээ. Бароны тушаалаар Лувсанцэрэн зуут зохион байгуулж,

## 100 ЖИЛ

Богд гэгээнийг Их хүрэнээс Манзуширын хийд рүү босгуулан авчрах операцыг ерөнхийд нь удирдсан бөгөөд зуутын дарга, дэслэгч Туванов Цэрэндаш Жигмитовичээр ахлуулан шууд дайран орж, ар хударгаар нь Богд Гэгээнийг хатантай нь жууздан суулган Туул гол хүргээд, цааш нь мориор Богд уулыг давуулжээ. Барон анх ирэхдээ 800 цэрэгтэй ирсэн атал Гүн Галуутайд гурван сар болоход, Халхын ноёдын

"Хатанбаатар Ван Магсаржавыг Цэргийн яамны тэргүүн дэд сайд байхад, дараа нь Цэргийн яамны жинхэнэ сайд болоход нь орчуулагч-зөвлөхөөр нь ажилласан юм. Баатар Ванг 1927 онд нас барахад Монголын Ардын Хувьсгалт Цэргийн Улс төрийн газрын дарга, комиссар болж 1933 он хүртэл ажилласан. Коминтерний төлөөлөгчөөр 1921 онд түр ажилласан тухай мэдээ олж уншсан. Л.Цэвээнэв нь Монгол

УИХ-ын гишүүнээр сонгогдсон бөгөөд МоАН-ын анхны ерөнхий нарийн бичгийн дарга, МоАХ-ны даргаар ажиллаж, Монгол Улсыг зах зээлийн эдийн засагт шилжүүлэх концепц боловсруулах ажлын хэсгийг ахалж байлаа.

Ингээд цаг нь ирсэн тул дараах саналыг дэвшүүлж байна.

1.Нийслэл хүрээг чөлөөлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, цаашид жил бүр тэмдэглэж байх,

# ТӨЛӨӨ ЗҮТГЭСЭН ЦЭВЭЭНОВ ГЭЖ БАЙВ?

дэмжлэгээр сайн дураар хүмүүс хүрээлэн нэгдэж, Хүрээ рүү довтлоход цэргийнх нь тоо 2600 болсон байжээ. Чөлөөлөгдсөн Нийслэлд өвөө маань дэг журам сахиулан, Өндөр хогийг цэвэрлэх санаачилгыг анхлан гаргаж, Бароны тушаалаар цэвэрлүүлжээ.

Өндөр хог нь одоогийн Улсын Их дэлгүүрээс зүүн тийш Сүхбаатарын талбай хүртэлх өргөн талбайг эзэлдэг байжээ. Ямартаа л тэр үеийн хүмүүс "Хүрээнд хоёрхон өндөр бий. Нэг нь Мигжиджанрайсаг, нөгөөх нь өндөр хог хэмээн хошигнодог байх вэ дээ. Баатар Ван, Дилав хутагт болон бусад дээдсүүд өөр хоорондоо хэлцээд, "Цагаантан цаашид явцгүй болсон тул Улаантан нь бодитой юм байна" гэсэн дүгнэлтэд хүрцгээжээ. Хиагтыг чөлөөлөхөд Ардын журамт цэргийн бүрэлдэхүүнд "Казачий полк"-ын командлагчийн нэг, удам дамжсан офицерын хувьд манай өвөө тодорхой үүрэг гүйцэтгэжээ. Унаган орос хэлтэй тэр бээр, Хатанбаатар Ван Магсаржавын

Ардын Хувьсгалт Цэргийн анхны дүрмийг боловсруулалцаж, армийн амьдралд хэрэгжүүлэгчдийн нэг байв. Мөн хотын комендантын дүрмийг боловсруулжээ. Тэр бээр Ёслолын албыг санаачлан байгуулсан эрхэм хүмүүн билээ" гэж тэмдэглэн үлдээсэн байна. Өвөөгийн маань хөргийг Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хүндэтгэлтэй байрлуулсан байдаг нь яах аргагүй үүсгэн байгуулагчийн нэг гэж үздэгтэй холбоотой билээ.

Тухайлбал, Улаанбаатар хотын комендант, захирагчаар 1924-1926 онд ажиллаж, 1926 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 0110 тоот тушаалаар Дарга нарын хэлтсийг хариуцсан Жанжин штабын орлогчоор томилогдсон байдаг. Энэ тухай баримт Монгол цэргийн музейн сан хөмрөгт тавигдсанаас тодорхой харж болно. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад дагаар орох тухай бичсэн өргөдөл, гар буу, партизаны 65 дугаартай үнэмлэхний хуулбар нь хадгалагдаж байна. Тийнхүү Цэргийн яамны тэргүүн дэд

2.Хиагтыг чөлөөлөх байлдааны үйл явцыг нарийвчлан тодруулах,

3. Эрхэм хүн Л.Цэвээнэвын амьдрал үйл ажиллагааны талаар тодорхой судалгаа хийж, нийтийн хүртээл болгох. Учир нь энэ эрхэм хүн Барон Унгерны удирдлагад Хатанбаатар Ван Магсаржавтай багагүй хугацаанд хамт байсан нь улс төрийн хувьд бүдгэрэх шалтгаан болсон. Энэ хүнийг алдаршуулахын тулд аль нэг анги, нэгтгэлийг түүний нэрэмжит болгох,

4. ОХУ-ын ГХЯ-ны архиваас холбогдох бичиг баримт,

а/ тэр үеийн цэргийн гэрээ хэлэлцээр, оролцогчийн талаар мэдээлэл авах,

б/ 1000 цэргийн түүхийг нууцаас чөлөөлүүлэх хүсэлт тавьж Монголын талд авах,

5.Нийслэл хүрээг чөлөөлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх комисс байгуулах тухай Ерөнхийлөгчийн зарлиг эсвэл цаашид тэмдэглэж байх Соёлын яамны сайдын тушаал гаргах,



Охин Л.Дэжиддулам, хүргэн З.Төмөртоогоо, бага хүү Л.Лувсангончиг нар



Хүү Л.Лувсангончиг, охин Л.Дэжиддулам нар

түүний удирдлагад Нийслэл хүрээг чөлөөлөхөд оролцсон хамтран зүтгэгчид болох монгол, барга, буриад, халимаг цэргүүдэд зориулсан дурсгалын хөшөө цогцолбор байгуулах. Мөн Богдын хоригдож байсан, Бароны байрлаж, амьдарч байсан байшингуудыг улсын түүхэн дурсгалт газруудын бүртгэлд бүртгэх, хамгаалалтад авах,

8. 1911 оны Үндэсний эрх чөлөө, 1921 оны Ардын хувьсгалын түүхэн үйл явдалд идэвхтэй оролцсон барга, буриад, халимаг, өвөрлөгч нарын оролцоог цаашид судлан, цагаатгах, нэр төрийг нь

дүрмийг эмхлэн цэгцлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан, мөн Хүндэт харуулын ангийн үндэс суурийг тавилцсан түүхэн гавьяатай, халуун сэтгэлт эх оронч байжээ. Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн 90 жилийн ойд зориулж, 2014 онд эмхэтгэн хэвлүүлсэн "Хоёр зууны түүхтэй хотын комендант" номын "Нийслэл Улаанбаатар хотын комендант байгуулагдсан нь" хэсэгт Л.Цэвээнэвын талаар нэлээд дэлгэрэнгүй бичсэн байдаг. Мөн УБХИС-иас эрхлэн гаргадаг "Соёмбо-УБХИС" хавсралт дугаарын 2021.01.28 №02(177)-д доктор, профессор И.Чинбатын бичсэн "Тэдний баатарлаг үйл хэрэг, гавьяа зүтгэлийг алдаршуулан мөнхжүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор тулгарч байна" нийтлэлд "...Даргын сургуулийн удирдлага, багшлах бүрэлдэхүүнд багагүй өөрчлөлт гарч, захирлаар К.К.Баторун, В.И.Дмитренко, улс төрийн туслах Н.Насанбат, канцлярын дарга Григоренко, сургалтын ангийн дарга К.Баторун болон цэргийн хэргийн багш Л.Цэвээн, ерөнхий эрдмийн багш Дашиев, монгол хэл бичгийн багш Мөрцэрэн, Цэдэн-Иш, Данзан, орон тооны бус багш Ц.Жамсран, Батхаан, Н.Жадамба зэрэг бичиг соёлын нэрт төлөөлөгч, эрдэмтэн мэргэд томилогдон ажиллаж, Ардын цэргийн даргалах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх үйлсэд хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэсэн нь нэн бахархалтай юм" хэмээн тэмдэглэжээ. Тийм учраас ид хийж бүтээх цэрл залуу насандаа учир битүүлээр амь насаа алдсан Л.Цэвээнэвын амьдрал замналыг цаашид гүнзгийрүүлэн судлах, улмаар мөнхжүүлэх зайлшгүй шаардлага буй нь тодорхой байна.

МЗЭ-ийн шагналт, зохиолч, сэтгүүлч Гомбын БААТАРНУМ



Ач Л.Тунгалаг, С.Билэгсайхан нар

шадар хүний хувьд Монголын талаас идэвхтэй байр суурь эзэлж, Зөвлөлтийн талтай хэлэлцээр хийхэд нөлөөлсөн нь дамжиггүй. Л.Цэвээнэв нь 1921 онд Цэргийн бага даргын сургуулийг үүсгэн байгуулалцаж, анхны сургагч багш болжээ. Энэ тухайд хошууч генерал Г.Эрэндоо нэг бус удаа "Цэвээн бол бидэнд морин цэргийн тактикийн сургууль заадаг, цэргийн хэргийн өндөр мэдлэг боловсролтой багш байсан юм" хэмээн дурсжээ. Мөн тус сургуульд пулемётын багшаар ажиллаж байсан Ардын журамт цэргийн партизан Анандын Мягмар гуай дурсамждаа энэ тухай өгүүлсэн байдаг.

сайд, сайдын зөвлөх байсны хувьд Шинэ тулгар улсын Зэвсэгт хүчнийг шинээр эмхлэн зохион байгуулах, зэвсэг техникээр хангах, бие бүрэлдэхүүний цэрэгжилт, жагсаалч байдал хийгээд байлдааны бэлэн байдлыг тогтмол дээшлүүлэх, мөн Зөвлөлтийн Улаан Армитай болон Зөвлөлтийн БХЯ-тай хийсэн гэрээ хэлэлцээрт идэвхтэй оролцож байсан нь зайлшгүй. Цаашид энэ талаар нэлээд дэлгэрэнгүй судлах шаардлагатай гэж боддог.

Миний хувьд, 1990 онд АИХ-ын депутатаар сонгогдон, Шинэ Ардчилсан Үндсэн хууль батлалцсан. Мөн 1996-2000 онд

... Эрхэм хүн Л.Цэвээнэвын амьдрал үйл ажиллагааны талаар тодорхой судалгаа хийж, нийтийн хүртээл болгох. Учир нь, энэ эрхэм хүн Барон Унгерны удирдлага дор Хатанбаатар Ван Магсаржавтай багагүй хугацаанд хамт байсан нь улс төрийн хувьд бүдгэрэх шалтгаан болсон. Энэ хүнийг алдаршуулахын тулд аль нэг анги, нэгтгэлийг түүний нэрэмжит болгох ...

сэргээх, улмаар алдаршуулах зэргээр цаашид судалж, авч хэрэгжүүлүүштэй түүхэн олон баримтыг сөхөн тавьжээ.

**С Э Т Г Ү Ү Л Ч И Й Н**  
ЗУРВАС: Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө амь хайргүй тэмцэж, тодорхой цаг үед тодорхой ажил алба хашиж явсан Л.Цэвээнэв нь Цэргийн бага даргын анхны сургуулийг үүсгэн байгуулацгаж, тухайн үеийн Монгол Ардын хувьсгалт цэрэг, өнөөгийн Зэвсэгт хүчний анхны

# Л.Жамбалжав: АМЬДРАЛДАА ТӨРӨЛ БҮРИЙН ХУВЦАС ӨМССӨН Ч ШИНЕЛЬ ШИГ ЭЭ НАНДИГНАЖ ҮЗЭЭГҮЙ

(Түрүүч нь I нүүрт)

**Залуухан мэс заслын эмчид цэргийн хүн болно гэсэн бодол хэдийд нь төрөв?**

-Манай удамд цэргийн хүн байгаагүй. Түрүүнд хэлсэнчлэн аав минь дайнд оролцож, баатарлаг гавьяа байгуулж явсан учир бид бага балчир цагаасаа л эх орон гэж ямар үнэ цэнтэй зүйл болохыг ааваасаа үлгэрлэж өссөн. Би гэдэг хүн хэдий анагаах ухааны салбарт хөл гишгэсэн ч цэргийн хүн болох сон гэдэг нууцхан бодол байнга дагалдаастай. Тиймээс гэнэтхэн л цэрэгт явъя гэсэн бодол төрсөн. Улмаар 1974 онд цэргийн албанд өөрийн саналаар явахаар шийдэж, Зүүнбаянгийн 126 дугаар нэгтгэлд томилогдон 1000 цэргийн карантинаар дамжиж явлаа.

Тэгтэл тухайн үед армийн хэмжээнд мэс заслын эмч мэргэжилтэй над шиг хүний хэрэгцээ туйлын их байсан учир цэргийн албыг гуравхан сар хаагаад Батлан хамгаалахын сайдын тушаалаар дэслэгч цолоор шагнуулж, Цэргийн төв эмнэлэгт туслах эмчээр томилогдсон. Цэргийн төв эмнэлэгт л цэрэг хүн, тэр дундаа цэргийн эмч ямар өндөр хариуцлагыг нуруундаа үүрч явдаг талаар ихийг сурч мэдсэн. Тэр эмнэлгийн гадаах хашаа, байшин, хагалгааны өрөө, тасалгаанууд одоо ч миний сэтгэлд хамгийн дотно чигээрээ үлдсэн. Эмнэлгийн хаалгаар орох мөч миний хувьд хамгийн аз жаргалтай цаг хугацаа байдаг. Арга ч үгүй биз, залуу халуун үеийн галтай цогтой дурсамжууд тэнд үлдсэнээс гадна амьдралынхаа ханийг хүртэл олж хувь заяагаа холбож байсан дурсамж дүүрэн газар минь юм шүү дээ.

**Цэргийн эмч хэмээх энэ хариуцлагатай албанд зүтгэхэд хамгийн их үлгэр дуурайлал болж байсан хүн хэн бэ?**

-Үнэндээ Цэргийн төв эмнэлэгт нэгэн үед ажиллаж байсан олон ахмад эмч нарын нэрийг дурдмаар байна. Жишээ нь, хурандаа Б.Дамбийням, Д.Чойжилжав, Б.Сандан, Д.Сүхбаяр зэрэг мундаг хүмүүсийн гар дээр би жинхэнэ цэргийн эмч хүний эрдэм мэдлэгийг анх олж авсан. Тэдгээр эрхэм хүмүүс надад эмч хүн бие дааж юм сурдаг гэдгийг маш сайн ойлгуулсан. Тиймээс би ном, сэтгүүл маш их уншдаг байсан. Надад баяр наадам, амралтын өдөр гэж байдаггүй, үргэлж номын санд өнжинө. Миний хамтран зүтгэгч нар маань ч надад их дэм болсон. Дээрээс нь хөдөө томилолтоор явах, удаан хугацааны хээрийн дадлагад гарах, гадаад оронд сургуульд суралцах үед миний арыг эхнэр маань бүрэн хариуцаж байсан. Эднийхээ хүчид л би өдий зэрэгтэй яваа гэж боддог.

1982 онд Батлан хамгаалах яамны удирдлагууд надад итгэл хүлээлгэж, Ленинград хотын Цэргийн хүмүүнлэгийн академид суралцаж докторын зэрэг хамгаалах боломжор хангасан. Дараа нь 1990-ээд оны эхээр МУИС-ийн англи хэл судлалын ангийг төгсөж, улмаар АНУ-ын Батлан хамгаалах яамны Англи хэлний институт, АНУ-ын Хуурай замын цэргийн академид тусгай мэргэжлийн дамжаанд суралцсан. Америкт байхдаа эрхтэн шилжүүлэх мэс заслыг анх удаа харж, хагалгаануудад дагалдангаар ажиллаж үзсэн. Тэр үеэс хүний эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааг эх орондоо



нутагшуулах тухай бодол орж ирсэн. Европын анагаах ухаан манай оронд хөгжөөд бараг 100 шахам жил болохдоо шинээр олон ололт амжилт нэвтрүүлж байсан ч хүний эд эрхтэн шилжүүлэн суулгах арга тухайн үед хараахан нэвтрээгүй байсан. Өөрөөр хэлбэл эрхтэн шилжүүлэн суулгахын оронд муудсан, гэмтсэн хэсгийг шуудхан л тайрчихдаг байлаа. Хамгийн гол нь бүтэн эрхтэн байхгүй л бол хүн гэдэг амьтан нөгөө эрхтнээрээ дутах, улмаар бусад эрхтэнд нөлөөлж эхэлдэг учир эд эрхтэн шилжүүлэн суулгах аргыг судлах зайлшгүй шаардлага тулгарсан. Тийм ч учраас би энэ талын судалгаа шинжилгээнд цагаа түлхүү зарцуулж эхэлсэн.

**Бөөр шилжүүлэн суулгах анхны хагалгаа ямар явцтай болж өнгөрсөн бэ? Магадгүй таны санаа бодолд тод үлдсэн байх?**

-Цэргийн төв эмнэлэгт эмчээр ажиллаж байсан намайг 1996 оны эхээр дээд удирдлагаас шууд Эрүүл мэндийн яаманд газрын даргаар томилсон. Залуу халуун үеэсээ эхэлж 23 жил ажил, амьдралаа холбож явсан эмнэлэгтээ хоргодох сэтгэл их байсан. Гэвч цэргийн хүн тушаалаар хөдөлдөг учир тэр даруй ажлаа хүлээлгэж өгөөд Эрүүл мэндийн яаманд шинельтэйгээ очиж байлаа. Тэр үе бол манай орон зах зээлийн нийгэмд шилжсэн хүнд цаг байсан. Үүнийг дагаад эрүүл мэндийн салбар ч уналдаг байсан болохоор хэд хэдэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага бий болж Эрүүл мэндийн, Ариун цэврийн, Эмийн тухай зэрэг хуулийг санаачлах ажлын хэсэгт орж ажилласан. Хамгийн гол нь бид эд эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааг эх орондоо нутагшуулах горьдлоготой байлаа. Гэтэл 1996

оны 7 дугаар сард бөөрний дутагдалд ороод бүүр сэхээнд орчихсон найман хүүхэдтэй айлын бага нь болох 22 настай залуу бараг л үхлээ хүлээж байна гэсэн мэдээ ирлээ. Бөөрний дутагдалд орсон хүний шээсний хорыг аппаратаар цэвэрлэдэг байтал зүрхний дутагдалтай байсан учир ямар ч боломж байхгүй байв. Бид хоорондоо зөвшилцөөд ямар ч байсан амьд бөөр тавьж үзье гэсэн дүгнэлтэд хүрлээ. Гэтэл 26 настай эгч нь нэг бөөрөө өгөхөөр болов. Хүний эгч гэж үнэхээр гайхалтай юм гэдгийг тэгэхэд мэдэрч билээ.

Бид хагалгааг Улсын клиникийн нэгдүгээр эмнэлэгт Төрийн соёрхолт Д.Нямсүрэн, Төрийн шагналт Ж.Нарантуяа, Б.Гоош багш, Хөдөлмөрийн баатар Г.Нямхүү эмч нарынхаа нөмөр нөөлгөнд амжилттай хийж байсан. Хагалгааны дараа шилжүүлэн суулгасан бөөр шээс ялгаруулж хордлогоос гарч чадсан. Тэгэхдээ өөр хүний бөөр суулгасан болохоор хүнийрхэнэ гэдэг том асуудал гарлаа. Тухайн үед бидэнд одоо үеийнх шиг дархлаа дэмжих эм тариа байгаагүй. Харамсалтай нь өвчтөн зүрхний дутагдалтай байсан учир долоо дахь хоног дээрээ цусан бүлэм үүсэж бөөр нь ажиллагаагүй болсон. Бид хэсэгхэн хугацаанд ч гэсэн тэр залуугийн амийг аврах оролдлого хийсний хүчинд өвчтөн маань гурван сар гаруй амьдарсан. Тэгэхдээ энэ мэс засал Монголын анагаах ухаанд маш их түлхэц өгсөн. Тухайн үед ард түмэн эрхтэн шилжүүлэн суулгах талаар ямар ч ойлголтгүй байсан бол тэр хагалгаанаас хойш олон аав ээж, эгч дүүс, охид хөвгүүд хайртай хүмүүсийнхээ төлөө бөөрөө өгч амьдрал бэлэглэдэг болсон.

Бид анхны мэс заслаасаа хойш гаднын орнуудаас туршлага судлах, сургандадлагуулах зайлшгүй шаардлага бий болсон. Улмаар миний бие Анагаах ухааны хүрээлэнд шилжин ажиллахдаа тэр тухай төсөл бичээд Бээжин хотын "Найрамдал" эмнэлэгт мэс заслын багаа дадлагажуулахаар боллоо. Дараа нь уг төслийн дагуу Солонгос, Англи Улсаас буцалтгүй тусламжаар хагалгаанд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, молекул, биологийн лабораторийг анх нэвтрүүлж, зарим эмч нарыг өндөр хөгжилтэй орнууд руу сургалтад явуулж чадсан. Ер нь энэ талын судалгаа шинжилгээ хийх, баг хамт олныг сурган дадлагажуулаа гэдэг маш их хөрөнгө, төсөв шаардлагатай юм байна лээ. Олон ч хүнээс мөнгө гуйж үзсэн. Аль болох л улсдаа нэртэй, нөлөө бүхий бизнес эрхлэгчидтэй уулзаж мөнгө зээлэх талаар ярилцаж байсан. Зарим нь үнэхээр монгол хүний эвсэг, сайхан сэтгэлээр тус хүргэж байв. Зарим нэг нь ганц ч төгрөг гаргаагүй.

Бидний хамгийн анхны амжилт олсон бөөр шилжүүлэн суулгах хагалгаа 2006 онд хийгдсэн. Чухамдаа 2005 оны сүүлээр хоёр ихрийн нэг нь бөөрний дутагдалтай байсан тул нөгөө ихрийнх нь бөөрийг шилжүүлэн суулгах шаардлагатай болсон. Би тухайн үед ажлаасаа халагдчихаад жижиг хувийн эмнэлэг ажиллуулж байсан юм. Юуны түрүүнд хагалгааны багаа Бээжинд дахин дадлагажуулах ёстой гэж бодсон. Гэтэл бидэнд бас л мөнгө олдсонгүй. Харин миний төрсөн дүү Англид хараар ажиллаж олсон мөнгөө зээлэхээр болж манай баг 12 дугаар сард Бээжин хотод дадлагажуулахаар болсон. Буцаж ирэхдээ манай багийнханд зааж сургаж байсан Бээжингийн эмнэлгийн эмч нараа Монголд урьж авчраад хагалгааг найдвартай байлгах үүднээс хамтарч хийх санал тавьсан. Ийнхүү хоёр ихрийн бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг А.М.Шастины нэрэмжит гуравдугаар эмнэлэгт аль болох хүмүүсийн хөдөлгөөн багатай үед буюу хагас сайн өдөр хийж байсан. Хагалгаа тун амжилттай болсон учир маргааш нь хэвлэлээр зарлаж байлаа. Энэ үйл явдал ч мөн адил манай орны анагаах ухаанд том түлхэц болж чадсан. Үүнээс хойш бид бие дааж хагалгаа хийдэг болсон. Өнөөдрийн байдлаар нийт 233 хагалгаа хийсэн гэсэн тоо бий. Үр дүн 98.6 хувьтай. 1.4 хувь нь бусад өвчлөлөөр нас барсан болохоос биш бөөр шилжүүлэн суулгах хагалгаатай холбоотой техникийн хүндрэл гараагүй.

Ингэж л эд эрхтэн суулгах эмчилгээ манай оронд хөгжиж эхэлсэн дээ.

**Эмч хүн олон гавьяат үйлсийг бүтээдэг гэдгээрээ онцлогтой мэргэжил. Таны хувьд хүнд хүргэсэн хамгийн том тус юу вэ?**

-Намайг Нэгдүгээр эмнэлгийн дарга байхад нэг ээж хүүгээ үзүүлэх гэсэн юм гээд орж ирлээ. Өвчтөнийг харахад бие нь битүү хавангаж, хүндээр амьсгаадсан, хөл дээрээ удаан зогсож чадахгүй ширээ тулан зогсож байгаа 10 настай хүү байсан. Хүн бөөрний дутагдалд орсон үед цээж, хэвлийн хөндийгөөр ус дүүрч эсүүд нь хавангадаг. Гэтэл тэр 10-хан настай хүүд тийм хурц хэлбэрийн шинж тэмдэг илэрэхгүй хараад миний нулимс өөрийн эрхгүй гараад буруу харсан. Тэр даруй эмнэлгийн Бөөрний тасгийн дарга байсан Б.Бямбадаш эмчийг өрөөндөө дуудаж харуулахад маш түргэн шуурхай арга хөмжөө авч долоохон хоногийн дотор хаванг нь эмчлээд гэр рүү нь буцаасан. Хожим ээж нь хүүг минь хараад үйлсэн эмч хэн бэ гэж асуулгасан байсан. Тэр үед л би тэр хүүд том тус хүргэлээ дээ гэж бодсон. Би олон хүнийг эмчилж, олон хүнээс баярласан, талархсан сэтгэгдлийг нь сонсож байсандаа баярлаж явдаг. Гэхдээ энэ бол миний эмч хүнийхээ хувьд монголын анагаах ухаанд үзүүлж буй өчүүхэн тус гэж бодож явдаг. Би үхэн үхтлээ эх орныхоо төлөө, ард иргэдийг шударга, эрх тэгш, зовлон зүдгүүргүй байхын төлөө зүтгэх болно.

**Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Төрийн соёрхолт шагнал хүртэхдээ цэргийн хувцсаа өмсөж хүндэтгэл үзүүлснийг тань харсан. Цэргийн хүн гэдгээрээ хэр бахархдаг вэ?**



-Бахархалгүй яах вэ. Би амьдралдаа төрөл бүрийн хувцас өмсөж байсан хэдий ч цэрэг шинель шиг ээ нандигнаж үзээгүй. Тэр ч бүү хэл Эрүүл мэндийн яаманд газрын дарга байхдаа Монгол цэргийн баярын өдөр цэрэг хувцсаа өмсөөд ажилдаа явдаг байлаа. Нөгөө талаараа намайг өдий дайны мэс заслын эмч болох үндэс суурийг тавьж өгсөн нь Монголын Ардын Арми байсан учир Монгол Улсын Ерөнхийлөгч, Зөвсөгт хүчний Ерөнхий командлагчид илтгэл өгч энэ хүндтэй шагналаа авъя гэж бодож цэрэг хувцсаа өмссөн.

Нэг түүхийг сөхөж ярья гэж бодлоо. Би Цэргийн төв эмнэлэгт туслах эмчээр ажиллаж байгаад 1978 оны намар Зүүнбаянгийн 126 дугаар нэгтгэлд эмнэлгийн ротын захирагчаар ахлах дэслэгч цолтой томилогдсон юм. Тэр үед Хятадын арми Вьетнам руу дайрч, Вьетнамын хойд талын мужуудыг бүрэн эзлээд нийслэл Ханой руу дайрахаар эзхэж байсан хүндхэн цаг таарсан. Вьетнам Улсад социалист системийн орнууд туслахаар болсны дотор Монгол, Зөвлөлт хоёр орон багтаж байв. Улмаар 1979 оны 2 дугаар сарын 17-ны шөнө бид анги дээрээ түгшүүрийн байдалтай хоносон. Тухайн үед эхнэр маань жирэмсэн байсан болохоор хадам аав ээждээ хүүхэд эрүүл саруул бойжиж байгаа талаар хэлэх санаатай Зүүнбаянгийн холбоо орхоож явтал нэг байлдагч араас гүйж ирээд түгшүүр зарласан талаар дуулгалаа. Тэгээд шууд гэр рүүгээ очоод цагаан нэхий дээл, эсгий гутал өмсөөд анги руу гүйхээрээ очла. Би бодохдоо гэнэтийн дайралтад бэлдэхээр хээрийн дадлага, сургууль хийх нь дээ гэж таамагласан. Намайг анги дээр очтол Дорноговийн Авто баазаас 20 орчим машин ирээд эмнэлгийн байрыг тэр чигээр нь нүүлгэн хээр буулгачав. Бид ч хээрийн эмнэлгийнхээ хагасыг нь дэлгээд бэлэн байдлыг хангалаа. Хоёрдугаар сар учир асрын доогуур хүйтэн салхи салхилаастай, нэлээн зутруу. Үлдсэн дэлгэгдээгүй асруудаа дэмий байлгаж байхаар гээд Зүүнбаян руу ачуулчлан. Тэд удалгүй хүмүүсийн унтах цаг боллоо. Гэтэл шөнө 3 цагийн үед намайг штабаас дуудаж байна. Штаб дээр гүйгээд очтол хожим Батлан хамгаалахын сайд болсон Ш.Жадамбаа генерал (тухайн үед хурандаа байсан), Ар талын газрын дарга Я.Дамдинжав генерал, Ар талын газрын Эмнэлгийн хэлтсийн дарга, хурандаа н.Погной тэргүүтэй хэд хэдэн генерал, ахлах офицерууд сууж байна. н.Погной хурандаа над руу харснаа "Нөхөр минь чамайг цэргийн шүүхэд шилжүүлнэ. Чи ямар санаагаар хээрийн эмнэлгийн талыг буцаасан бэ" гэв. Би ч их шартай хүн учир тайлбар тавилгүй дуугай зогсоод байв. Я.Дамдиндорж генерал бид хоёрын яриаг таслан "Миний хүү хэчнэнх хүнд хагалгаа хийсэн бэ" гэж байна. Би ч 10-аад хүнд хагалгаа хийсэн талаараа хэллээ. Тэгтэл генерал "Одоо бид байлдааны байдалд шилжиж байна. Хятадын арми манай хилийн дагуу хүчээ байрлуулсан. Бид одоо тийш явна. Байлдаж ч магадгүй. Үлдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжөө бүгдийг нь авчир. Цагийн дараа бэлэн байгаарай" гэж үүрэгдлээ. Үүрэг өгч дуусахтай нь зэрэгцээд би бушуухан гурван машин дагуулаад Зүүнбаян руу буцаж нөгөө эмнэлгийн хэрэгсэлүүдээ авчрахаар болов. Замаараа эхнэртээ "Хээрийн сургуульд явлаа, удах байх" гэж хэлээд халаасанд байсан 75 төгрөгөө өгчихөв. Тэгээд "Хүүдээ битгий зовоорой. Эх орныхоо төлөө явлаа" гэж аав ээждээ захидал бичиж дугуйлаад хажуу айлдаа "Манай гэрийнхнээс цэргийн баяраар хүмүүс ирэхээр өгөөрэй" гээд, түлхүүртэйгээ хамт үлдээгээд буцаад явсан. Үнэндээ эргэж ирэхгүй л гэж бодсон хэрэг. Үүрээр бид урд хилийн зүг марш үйлдэж байлдааны бэлэн байдалд оров. Гэтэл удалгүй Зөвлөлт, Вьетнамын удирдлагууд "Хэрэв Вьетнам Улс руу гадаадын цэрэг довтолбол Зөвлөлтийн цэрэг шууд байлдаанд орно" гэсэн гэрээ хийж, дараахан нь ЗХУ-ын зүгээс Хятадын Засгийн газарт "Танайх нэн даруй тулалдаанаа зогсоож Вьетнамаас цэргээ татаж гарга. Эс тэгвэл бид дайран орлоо" гэсэн шаардах бичиг өгтөл хятадууд тэр даруй цэргээ татаж байсан. Хэрэв тухайн үед өөрөөр шийдсэн бол гарцаагүй ширүүн байлдаанд орох байсан. Тэгээд л бид бөөн баяр болоод буцаад цуваа татуулсан даа. Зүүнбаян руу буцах замд Г.Салманов генерал надад баярын бичиг, нэг бугуйн цагтай хамт дурсгахад Армийн Улс төрийн газрын дарга Т.Алтангэрэл генерал надад баяр хүргээд "Жамбалжав эмчид баяр хүргэе. Чамайг шинэ алба хүлээж байгаа шүү" гэж билээ. Би ч удалгүй Цэргийн төв эмнэлэгтээ ахлах эмчээр томилогдож тушаал дэвшиж байсан түүхтэй. Тиймээс би цэргийн хүн гэдгээрээ бахархаж явалгүй яах вэ.

**Цэргийн хэмээх тодотгол бол та бүхний мэргэжил нэгтнүүдээсээ ялгарах нэг онцлог шүү дээ ...**

-Тэгэлгүй яах вэ, Цэргийн эмч нар эмчийн тангаргаас гадна цэргийн тангараг өргөдөг онцлогтой. Энэ нь ямар ч тохиолдолд бэлэн байдлаа хангаж, аль ч хүнд үед өчүүхэн ч тайлбар тавих эрх байхгүй гэсэн үг. Эмч хүн гэхээсээ илүү цэрэг хүн учир зөвхөн ахлах даргын тушаалаар үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс мэдэхгүй чадахгүй гэдэг үг ашиглах эрх бидэнд байхгүй. Жишээ нь, цэргийн мэс заслын эмч гэхэд дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн зэрэг цаг үеийн ямар ч хүнд бэрх үед тухайн өвчтөнд хагалгаа хийх бүрэн чадвартай байх ёстой. Дээрээс нь цэргийн эмч нар байнгын хатуу ширүүн нөхцөлд дадлага сургууль хийдэг. Энэ нь бидний ур чадвар, сэтгэл зүйн бэлэн байдал дээшлэхэд чухал ач холбогдолтой.

**Хойч үеийн залуучуудад хандаж юу хэлэх вэ?**

-Би олон шавьтай. Тэд нар маань олон ч том эмнэлгийг толгойлж явна. Монголын Анагаахын салбарт шинэ үе бий болж байна. Одоогийн залуучуудын өмнө олон боломж нээлттэй болсон. Ганц тавигдах шаардлага нь чадварлаг эмч болохын тулд бие дааж хичээх явдал юм. Хоёрдугаарт, эмч хүн зорилготой байх ёстой. Мэдээж хүн болгон жаргалтайгаар урт удаан хугацаанд амьдрахыг хүсдэг. Тэгэхдээ энэ бол зорилго биш. Миний үргэлж ярьдаг зүйл бол зорилго төсөөлж, түүндээ хүрэхийн тулд мөрөөдөх хэрэгтэй. "Мөрөөдөж байгаа хүн маш их баяр хөөрийг мэдэрдэг. Харин мөрөөдөл нь биелсэн хүн аз жаргалыг мэдэрдэг" гэсэн орос үг бий. Яг л үүн шиг зорилго тавь, мөрөөд, хүс, тэмц, хэрэгжүүл. Чи ялалтад хүрэх болно.

Дэд ахлагч Т.ИДЭР



# ҮХЭР ЖИЛ УЛС ОРНУУДАД ЯМАР СОРИЛТ АВЧРАХ ВЭ

*Дэлхийн дулаарал, байгаль орчны доройтлоос үүдсэн хүнсний хямрал, засаглалын төлөөх тэмцэл, геополитикийн ашиг сонирхлоос үүдэлтэй зэвсэгт мөргөлдөөнүүд ирэх жил буурахгүй хэмээн олон улсын судалгааны "Глобал трендс" байгууллага үзэж байна. Энэ талаарх сэдвийг АНУ-ын Үндэсний тагнуулын алба (dni.gov)-ны цахим хуудсанд илүү дэлгэрэнгүйгээр нийтэлжээ. Хэрэв олон улсын хурцадмал байдал нэмэгдвэл терроризмын үйл ажиллагааг идэвхжүүлэх гол хүчин зүйл болох аж. АНУ, Европын холбооны дэлхийн эдийн засаг дахь манлайлал буурснаар олон улсын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын санхүүжилт танагдаж, түүнийг дагасан хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлууд нэмэгдэнэ гэж судлаачид таамаглажээ.*

## АНУ

Тус улс нь Европ тивийн улсуудтай нэгэн адил эдийн засаг, нийгмийн хүнд сорилтуудтай үргэлжлүүлэн тулгарна. Орлогын тэгш бус байдал, ажилгүйдэл нэмэгдэж байгаа нь "Америк мөрөөдөл"-өөр амьдрах хүсэлтэй иргэдэд эргэлзээ төрүүлж эхэлжээ. 24-54 насны иргэдийн ажилгүйдлийн түвшин түүхэнд анх удаа 1930 оны их хямралын үетэй адил хэмжээнд хүрсэн байна. Дундаж давхаргын өсөлт 2015 онд таван хувиар нэмэгдсэн ч цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн удаашрал явагдсаар байгаа аж. Гэвч технологид суурилсан үндэстэн дамнанас том компаниудын өсөлт сайн байгаа учир Холбооны нөөцийн санд төдийлөн дарамт учрахгүй, иргэдийн амьжиргааны түвшин огцом буурахгүй, үл хөдлөх хөрөнгийн зах зээл тогтвортой байх нь. Гэвч арьс өнгөний үзэл нийгэмд эмзэг сэдэв байсаар зогсохгүй иргэдийн төрд итгэх итгэл буурч, зөвхөн Ардчилсан нам, Бүгд найрамдах нам ээлжлэн төр барьдаг жишгээс тус орны ард түмэн татгалзахыг хүсэж байна. Нөгөөтэйгүүр хөдөлмөрийн зах зээлд хүнийг орлох хиймэл оюун ухаан, роботын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь ажлын байрны хомсдол үүсэхэд шууд нөлөөтэй гэж дүгнэжээ. Үүний зэрэгцээ АНУ-ын дэлхий дэх манлайллын үүрэг, оролцооны тодорхойгүй байдал, холбоотнуудаасаа холдож байсан Д.Трампын гадаад бодлого үргэлжлэх үү гэсэн асуултын хариулт бусад улсад хүлээлт өндөртэй байна. Эцэст нь арьс өнгөний үзэл, үндэстэн, соёлын ялгаа зэрэг нийгмийн том асуудал оршоор байгаа ч хувь хүний эрх, эрх чөлөө, аз жаргал руу тэмүүлэх эрмэлзэл олон нийтийн дунд хүчтэй байдаг нь Америкийг нэгтгэдэг том үзэл санаа болсоор, мөн бусад улсаас ялгарах давуу тал хэвээрээ байсаар байх болно.

## Европ

Европын холбооны гишүүн орнуудын эв нэгдэл суларч байгаа нь бүс нутгийн аюулгүй байдал болоод эдийн засагт хурцаар нөлөөлнө. Евро бүсийн эдийн засаг султай орнууд донор орнуудын зээл тусламжид олон жил хамрагдаж байгаа нь инфляцын өсөлт, ажилгүйдэл, цагаачлал зэрэг асуудлыг араасаа дагуулж, Герман, Франц зэрэг далайцтай эдийн засагтай орнуудад илүү их дарамт учруулна. Цаашдаа цагаачдыг үзэн ядах үндсэрхэг үзэлтэй жагсаал цуглаан нэмэгдэж, үндэсний бодлого, мөрийн хөтөлбөртэй намуудыг засгийн эрхэнд гаргах үзэл улам дэлгэрнэ.



Их Британи Европын холбооноос гарснаар цаашид тус холбооноос гарах хүсэлтэй орнууд нэмэгдэнэ. Европын хүн амын хөгшрөлт, бууралтаас үүдсэн эдийн засгийн удаашрал үргэлжилж, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын татварыг нэмэгдүүлэх замаар

нийгмийн даатгалыг бүрдүүлэвч ихэнх хэсэг нь тэтгэврийн нөхөн олговорт зарцуулагдах тул эдийн засагт тун хортой нөлөө үзүүлнэ. Залуу ажилчдын хомсдолыг нөхөхийн тулд цагаачлалын бодлогыг эргэн харахад хүрэх ч үндэсний үзэлтэй нам, олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарна. Европ тивийн аюулгүй байдал улам хурцарна.

## Зүүн Хойд Ази

Солонгосын хойгийн эргэн тойронд хурцадмал байдал нэмэгдэж ойрын жилүүдэд ноцтой сөргөлдөөн үүсэх магадлалтай. Ким Жон Ун цөмийн болон пуужингийн хөтөлбөрөө хоёр дахин нэмэгдүүлж, АНУ-д заналхийлж болзошгүй холын тусгалтай пуужин бүтээх ажлаа эрчимжүүлээд байна. Бээжин, Сөүл, Токио, Вашингтон нь Зүүн хойд Азийн аюулгүй байдлын эрсдэлийг удирдах нийтлэг ашиг сонирхолтой боловч геополитикийн ашиг сонирхол, дайн байлдаан, түүхийн харилцан туршлагаасаа болж бие биедээ итгэхгүй байгаа нь хамтын ажиллагааг улам хүндрүүлж байгаа юм. Хойд Солонгосын өдөөн хатгалга, түүний дотор цөмийн болон баллистик пуужингийн нэмэлт туршилтууд үргэлжилсээр байгаа нь бүс нутагт тогтвортой байдлыг улам дордуулж, хөрш орнууд өөрсдийн аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалахын тулд нэг талт арга хэмжээ авч, Зүүн хойд Азийн байдал улам ээдрээтэй байх болно.

Ким Жон Ун Умард Солонгосыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цөмийн зэвсэгтэй улс болгохоор хатуу шийдсэн. Тэрбээр олон улсын цөмийн зэвсгээс ангижрах гэрээ, яриа хэлэлцээнд оролцох сонирхол багатай байгаагаа илэрхийлсэн бөгөөд 2012 онд Коммунист намын үндсэн хуульд Умард Солонгосын цөмийн статусыг албан ёсоор хуульчилсан билээ. Сөүл, Токио бүс нутаг дахь аюулгүй байдлаа хадгалахын тулд АНУ-ын цэргийн баазуудыг эх нутагтаа байршуулах сонирхол их байдаг ч өөрсдийн батлан хамгаалах чадваргаа нэмэгдүүлэхийн тулд цэргийн зардлаа үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх хандлагатай юм.

## ОХУ

Хойд хөрш нь хүчирхэг статусаа сэргээхийн тулд цөмийн зэвсэг, цэргийн шинэчлэл, хилийн чанад дахь оролцоогоо нэмэгдүүлэхийг чармайж байна. Ирэх жил ч гэсэн тус улсын эдийн засгийн зогсонги байдал үргэлжилнэ гэж судлаачид үзжээ. Хорин жилийн өмнөхтэй харьцуулбал эдийн засаг тогтвортой өсөж байгаа ч цаашдаа яах эсэх нь бүрхэг хэвээр буй. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт Европын орнуудтай харьцуулахад доогуур, хүн амын өсөлт зогссон зэрэг нь улсын хөгжилд таагүй нөлөө үзүүлнэ. Москва эдийн засгаа төрөлжүүлэх бодлогоо эрчимжүүлэхгүй бол иргэдийнхээ шүүмжлэлд хүчтэй өртөж, үндэсний үзэлтэй нам, эвсэл, холбоодын үйл ажиллагаа эрчимжих, хувь хүний эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн төлөөх олон нийтийн эсэргүүцэлтэй цөөнгүй удаа тулгарч мэднэ.

Москва, Бээжин хүчний тэнцвэрийг дэлхийн бөмбөрцгийн зүүн талд хадгалахыг хичээж, АНУ

болон барууны орнуудаас ирэх шахалтыг хамтын хүчээр даван туулах үүднээс түүхэндээ өмнө нь байгаагүйгээр маш ойр харилцаатай болсон. Тиймээс Орос, Хятад нь бүс нутагтаа өөр өөрсдийн улс төрийн болон эдийн засгийн сонирхлын давуу байдлаа хадгалахын тулд илүү шийдвэртэй, түрэмгий алхмуудыг хийж магадгүй. Түүнчлэн Америкийн холбоотнуудын бодлого, эрх ашгийг эсэргүүцдэг Зөвлөлтийн холбоонд багтаж байсан улсуудад зэр зэвсгийн тусламжаа нэмэгдүүлэх болно. ОХУ-ын баруун хилд улам ойртож буй НАТО-гийн хүчний шилжилтийг сулруулахын тулд цэргийн томоохон хэргийн сургуулиудыг явуулж, Батлан хамгаалах чадавхаараа халдашгүй дархан байдлаа нэмэгдүүлэхийг хичээх болно. Эцэст нь Орос бол дэлхийн хамгийн өргөн уудам газар нутагтай улс. Тиймээс их гүрний статусаа алдахгүй байхын тулд цөмийн зэвсэг тэдний гол хэзэр байсаар байна.

## Өмнөд Ази

Ирэх жилүүдэд АНУ-ын Хятадын эсрэг авч хэрэгжүүлж буй худалдааны дайнаас болж тус улсын эдийн засгийн өсөлт саармагжина. Энэ нь Энэтхэгийн эдийн засгийн хөгжлийг хурдасгах таатай нөхцөл болно. Энэтхэгийн батлан хамгаалах зардал жилээс жилд нэмэгдэж байгаагаас үзэхэд Ази тивд шинээр их гүрэн мэндэлж байна гэж ойлгож болох юм. Энэтхэг нь одоо хүртэл Афганистан, Пакистан, Хятадтай хилийн бүсийн маргаантай байгаа тул зөрчил улам ширүүсэх магадлалтай. Тус улс эргэн тойрондоо дайсагнасан улсуудтай илүү шийдэмгий хурц аргаар тэмцэл явуулах хандлагатай байна.

Энэтхэгийн эдийн засгийн тэлэлт, хурдацтай хөгжлийг сайшааж болох ч хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн доройтол, дэд бүтцийн хомсдолоороо Ази тивдээ сүүл мушгисан хэвээр байгааг санах хэрэгтэй. Тухайлбал, хоол тэжээлийн дутагдалтай хүүхдүүдийн тоогоороо Энэтхэг нь Африкийн аль ч улстай харьцуулшгүй өндөр байдаг. Мөн өөр нэг толгой өвтгөж буй асуудал бол Гималайн уулсын мөс эрчимтэй хайлж байгаагаас Бангладеш, Энэтхэг, Пакистан зэрэг улсад олон жилийн ган гагич нүүрлэж, зуу зуун сая хүн хүнсний дутагдалд ороход хүргэж болзошгүй.

**Ахмад М.МӨНХЗОРИГ**

# “ШИНЭ БҮТЭЭЛ, ОНОВЧТОЙ САНАА” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зэвсэгт хүчний материал, техникийн үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж ашиглах, бие бүрэлдэхүүний мэдлэгийг практикт бүтээлчээр хэрэглэх, цэргийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд инновацыг өргөнөөр нэвтрүүлэх “Шинэ бүтээл, оновчтой санаа” уралдааныг 2021 оны 2 дугаар сарын 10-аас 6 дугаар сарын 25-ны хугацаанд хоёр үе шаттай зохион байгуулахаар зарлаж байна.

### Нэг. Уралдааны зорилго:

Шинэ дэвшилтэт техник технологийн хөгжил, инновац, бие бүрэлдэхүүний бүтээлч санал санаачилгыг Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, байлдааны болон хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### Хоёр. Хамрах хүрээ, тавигдах шаардлага:

2.1. ЗХЖШ-ын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн Удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, ҮБХИС-ийн эрдэмтэн, профессор багш, офицер, ахлагч, сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, оюутан, ажилтан, алба хаагч, хувь хүн болон багууд.

2.2. Танилцуулж байгаа бүтээл нь судалгааны явцад туршилт хийгдсэн, практикт нэвтрэх боломжтой, аюулгүй байдал хангагдсан, материал, техникийн

хангалтын үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр болохуйц, сайжруулсан болон инновацын шинжийг агуулсан байвал зохино.

2.3. Шилдэг бүтээлийг ажлын хэсэг сонгон шалгаруулахдаа ил тод, шударга зарчмыг баримтлан дүгнэнэ.

2.4. Танилцуулж байгаа бүтээл нь Монгол Улсын оюуны өмч, зохиогчийн эрх эзэмшигчийн бүртгэлгүй байх.

### Гурав. Зохион байгуулагч:

3.1. ЗХЖШ-ын Материал, техникийн газар.

### Дөрөв. Зохион байгуулалт:

4.1. “Шинэ бүтээл, оновчтой санаа” шалгаруулах ажлын хэсгийн гишүүдийг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилно.

4.2. Уралдааны I, II шатанд хувь хүн болон баг оролцож болно.

4.3. ЗХЖШ-ын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн Удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, ҮБХИС-иас ирүүлэх бүтээлийн тоог хязгаарлахгүй.

4.4. Уралдааны I шат: 2021 оны 6 дугаар сарын 3-10-ны өдрийн хугацаанд.

4.4.1. Оролцогчид бүтээлийн тооцоо, судалгаа, техникийн үндэслэлийг боловсруулж, цахим (CD дээр буулгах) болон цаасан хэлбэрээр ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Техникийн хэлтэст “Шинэ бүтээл, оновчтой санаа шалгаруулах уралдаанд” гэсэн

тэмдэглэлтэйгээр 2021 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс өмнө мэдүүлгийн хамт ирүүлнэ.

4.4.2. Уралдаанд оролцогчдын цахим болон цаасан хэлбэрээр ирүүлсэн бүтээл тус бүрийн тооцоо, судалгаа, техникийн үндэслэлийг судлан, ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шилдэг 10 бүтээлийг шалгаруулж оролцогчдод мэдэгдэнэ.

4.5. Уралдааны II шат: 2021 оны 6 дугаар сарын 23-25-ны өдрийн хугацаанд.

4.6. Ажлын хэсгийн хурлаар уралдааны хоёрдугаар шатанд шалгарсан хувь хүн болон оролцогч баг нь бүтээлийнхээ танилцуулгыг "Microsoft Power Point" программ дээр бэлтгэн (бүтээл болон бүтээлийн загвар)-ын хамт 2021 оны 6 дугаар сарын 23-нд Зэвсэгт хүчний Материал, техникийн газрын 3 давхар 304 тоот танхимд танилцуулж хамгаална. Жич: Танилцуулгын хугацаа 5-10 минут.

### Тав: Дүгнэх журам:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн тухайн бүтээлийн туршилт, аюулгүй байдал, онолын ба практик ач холбогдол, материал, техникийн хангалтын үйл ажиллагаанд ашиглах бодит боломж зэрэгт өгсөн онооны нийлбэрийг дүгнэж 1,2,3 дугаар байр болон тусгай байрыг эзлүүлнэ.

### Зургаа. Шагналыг:

6.1. Нэгдүгээр байр 1-Цом, өргөмжлөл, хоёр сая төгрөг, “Найман шарга амралтын газар гэр бүлийн хамт (баг хамт олон оролцсон тохиолдолд багийн бүрэлдэхүүн) 3 хоног үнэгүй амрах эрхийн бичиг.

6.2. Хоёрдугаар байр 1-Өргөмжлөл, нэг сая таван зуун мянган төгрөг, “Найман шарга амралтын газар гэр бүлийн хамт (баг хамт олон оролцсон тохиолдолд багийн бүрэлдэхүүн) 2 хоног үнэгүй амрах эрхийн бичиг.

6.3. Гуравдугаар байр 1-Өргөмжлөл, нэг сая төгрөг, “Найман шарга амралтын газар гэр бүлийн хамт (баг хамт олон оролцсон тохиолдолд багийн бүрэлдэхүүн) 1 хоног үнэгүй амрах эрхийн бичиг.

6.4. Тусгай байр 1-Өргөмжлөл, таван зуун мянган төгрөг.

6.5. Ажлын хэсэг “Шинэ бүтээл, оновчтой санаа” уралдааны II шатанд шалгарсан оролцогчдын материалыг 2021 оны 6 дугаар сарын 25-нд шалгаруулж, дүнг “Соёмбо” сонины 7 дугаар сарын эхний дугаарт нийтэлнэ.

Холбоо барих хаяг  
Баянзүрх дүүрэг, Ажлын хэсэг:  
Гар утас: 92090080, 92090076,  
Энхтайвны өргөн чөлөө 51.

Факс: (976-51) 265914

Улаанбаатар хот:  
Имэйл хаяг: tsogjargal\_b@mail.gov.mn

Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газар

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ**

## ШИНЭ ҮЕ



## ХОББИ БИЙ ЮУ?

-Хүчний спортоор хичээллэх сонирхолтой. Мөн чөлөөт цагаараа аялах дуртай. Ойрын хугацаанд 21 аймгаараа аялж, монгол орныхоо үзэсгэлэнт газруудад очно гэсэн зорилготой байгаа. Одоогоор 14 аймгаар аялсан. Залуу байгаа дээрээ өөрийгөө хөгжүүлж, өөрийн сонирхсон хүссэн зүйлээ хийж үзэхэд буруудахгүй юм шиг санагддаг.

## ОХУ-д цэргийн сургуульд сурч байсан дурсамжтай мөчүүдээсээ хуваалцвал ...

-Өдөр бүр их дурсамжтай, заримдаа хөгжилтэй өнгөрдөг байсан. Ямар ч номоос олж уншихгүй зүйлсийг ойлгож мэдэрсэн. Манай сургуульд 16 орны 300 гаруй сонсогч суралцдаг байсан. Миний удирдсан салаанд Ангол Улсын Зэвсэгт хүчний сонсогчид мөр зэрэгцэн суралцдаг байв. Нэг удаа маршид уул өөдөө гүйж байх үед манай салааны нэг сонсогчийн хамраас цус гарчав. Энэ үед хажууд гүйж байсан ангол сонсогч халаасныхаа дотрыг урж цусыг нь сайн гэгч нь тогтоож өгсөн. Энэ үйл явдал санаанаас ер гардаггүй. Сэтгэлд тодоор үлдэж дээ.

## С.Ууганбаяр: ЭХ ОРНОО САНАСАН ҮЕД ХАМГИЙН САЙХАН МӨРТҮҮД СЭТГЭЛД БУУДАГ

**Зэвсэгт хүчний шинэ үеийн төлөөлөл дэслэгч С.Ууганбаяртай ярилцлаа. Тэрээр залуу офицер, ахлагч нарт хандаж "Эрхэлсэн ажил, албандаа хоёргүй сэтгэлээр тууштай зүтгээрэй. Хорвоо хэнийг шагнахаа мэддэг, нүдтэй гэмээр" гэж уриалгахан хэлсэн юм.**

## Өөрийгөө манай сонины уншигчдад танилцуулахгүй юу?

"Соёмбо" сонины уншигчдад энэ өдрийн мэндийг хүргэе. Би ОХУ-ын Вольск хотын цэргийн материал хангалтын их сургуулийг төгссөн. Одоо Зэвсэгт хүчний 013 дугаар ангид хангалт үйлчилгээний салааны захирагчаар ажиллаж байна.

## Цэргийн хүн болох санаа анх хэзээ төрсөн бэ?

-Миний аав, ээж, өвөө, эмээ гээд бүгд цэргийн хүмүүс. Би гэр бүлийн гурав дахь үеийнх нь офицер. Бага байхын цэргийн хувцас, байлдаантай кино гэх мэт цэргийн холбогдолтой зүйлд татагддаг байсан. Цэргийн хүн болох гэж төрсөн мэт. Өөр мэргэжилтэй болох талаар бодож байгаагүй.

## Таныг шүлэг бичих сонирхолтой гэж сонссон ...

-Багадаа зохион бичлэг, шүлэг бичихэд эмээ маань намайг их урамшуулдаг байсан. Эвлэгхэн бичихдэг гээд магтана. Ангийн багш ч ялгаагүй. Ингэж л усалж өндийдөг цэцэг шиг урмын үгэнд бялхсан би шүлэг яруу найраг оролдсоор бага зэрэг дөр суусан юм болов уу гэж боддог.

## Тэгвэл таны уран бүтээлд цэрэг-эх орны сэдэвтэй шүлэг зонхилдог байх даа?

-Тэгэлгүй яах вэ. ОХУ-д цэргийн сургуульд суралцаж байхдаа эх орноо санах, мөн Монгол Улсынхаа Зэвсэгт

хүчний бусад улсынхаас илүү гэдгийг мэдрэх, үндэснийхээ түүх уламжлалаар бахархах зэрэг онцгой мөчүүдэд өөрийн эрхгүй шүлэг тэрлэдэг байлаа. Зүрхний угаас гардаг болохоор гоё сайхан мөртүүд тэр үед сэтгэлд буух нь бий.

## Уран бүтээлийн ном товхимол гаргая гэж бодож үзсэн үү?

-Номоо гаргах гээд бэлдэж байна.

## Номонд мөнхрөх шүлгүүдээсээ дөрвөн мөртийг сонирхуулахгүй юу?

-Эрхэм дээд соёмбоо тэргүүндээ залахад Эрэлхэг Монголынхоо далбаанд сөгдөн мөргөхөд Түмэн зууны тэртээх баатруудын уухай зүрхэнд цуурайтаж

## Тусгаар тогтнолт ариун гал голомтынхоо удам залгах хүү гэдгээрээ би бахархана.

## Ангийнхаа талаарх сэтгэгдлээс хуваалцахгүй юу?

-Монгол Улсын баатар Рашмаагийн Гаваагийн нэрэмжит Байлдааны гавьяаны болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт холбооны Тусгай хороо гэх алдар, түүхтэй энэ ангид ажиллаж байгаагаа ховорхон тохиол гэж боддог. Тал бүрээр тусалж дэмждэг удирдлага, хамт олон, найз нөхдөдөө талархаж байгаагаа илэрхийлж, Та бүхнээс цаг ямагт суралцдаг шүү гэдгээ уламжилъя.

## Шүлэг бичихээс өөр

Энэ үед цэргийн амьдрал хаана ч, аль ч оронд хүндлэл, итгэлцэл дээр тогтдог гэдгийг зүрхнийхээ гүнд хүртэл ойлгосон үе тэр байж билээ. Товчхондоо бид өөр өөр орноос ирцгээсэн соёл, ёс заншил, уламжлалын хувьд ялгаатай ч цэргийн амьдралд дадахдаа нэг хүн шиг уусдаг байсан.

## Зэвсэгт хүчинд алба хааж байгаа залууст хөгжиж дэвших ямар боломж байдаг гэж боддог вэ?

-Хугацаат цэргийн алба хаагч та өглөө сэрээд орой амрах хүртэл өдөр бүр хөгжиж байдаг гэдгээ ойлгож ухамсарлах хэрэгтэй. Таны олж авсан мэдлэг туршлага амьдралд тань өдөр тутамдаа биш юм гэхэд алсдаа маш том хөрөнгө оруулалт болно. Харин офицер, ахлагч нарын хувьд шат шатны сургалт, хэлний дамжаа, олон улсын хамтарсан сургуульд хамрагдаж, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэснээр бие бялдар, мэдлэг чадвараараа дээшлүүлэх боломжтой. Энэ нь тухайн цэргийн алба хаагчийг цогц байдлаар хөгжүүлж байгаагийн зэрэгцээ нийгмийн хамгааллын асуудлаа шийдвэрлэх нэг гарц нь болдог.

## Сүүлчийн асуултыг танд үлдээе?

-Залуу офицер, ахлагч нартаа хандаж хэлэхэд, сурч боловсроход цаг хугацааг илүүтэй зарцуулаарай. Бид түүхэн цаг үед амьдарч буй нэг үеийн Зэвсэгт хүчний төлөөлөл. Зэвсэгт хүчний хөгжлийн өнгө төрхийг та биднээр тольдож ч болно. Тиймээс энэ салбарынхаа нэр хүндийг өндөрт өргөж яваарай хэмээн уриалж, үе тэнгийн цэргийн нөхдөдөө ажлын өндөр амжилт хүсье.

## У.БОЛОРЦЭЦЭГ

## Гуравдугаар сарг таныг юу хүлээж байна вэ?

### Эх орончдын өдөр /3 дугаар сарын 1/

1921 оны энэ өдөр жанжин Д.Сүхбаатар тэргүүтэй хувьсгалчид МАН-ыг үүсгэн байгуулж байсан түүхтэй. Хожим нь энэ өдрийг МАХН УИХ-д олонх байх үедээ Эх орончдын өдөр болгон тэмдэглэх шийдвэр гаргасан.

### Үндэсний сэтгүүл зүй үүссэн өдөр /3 дугаар сарын 6/

1913 оны 3 дугаар сарын 6-нд "Шинэ толь хэмээх бичиг" сонины анхны дугаар хэвлэгдсэн нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны суурь байсан юм. Энэхүү сонины эрхлэгчээр их соён гэгээрүүлэгч Жамсрангийн Цэвээн ажиллаж байв.

### Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр /3 дугаар сарын 8/

Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэх санаачилгыг 1910 онд Данийн нийслэл Копенгаген хотод болсон олон улсын эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын үеэр Германы эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгч Клара Зеткин санаачилжээ. Хамгийн анх 1911 онд олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг Австри, Дани, Герман болон Швейцар улсуудад тэмдэглэсэн байна.

### Монгол цэргийн өдөр /3 дугаар сарын 18/

Монгол Ардын журамт цэрэг Хиагтыг чөлөөлж анхны ялалтын тугийг мандуулсан энэхүү түүхт өдрийг БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар тогтоолоор "Хувьсгалт цэргийн баярын өдөр" хэмээн жил бүр улс даяар ёслон тэмдэглэх шийдвэр гаргаж байжээ. Дараа нь 2011 онд УИХ-аас "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар жил бүрийн энэ өдрийг "Монгол цэргийн өдөр" болгон тэмдэглэж эхэлсэн юм.

### Монгол хүн сансарт ниссэн өдөр, Наурызын баяр /3 дугаар сарын 22/

❖ Монгол Улсын иргэн, сансрын нисгэгч Ж.Гуррагчаа, ЗХУ-ын сансрын нисгэгч В.А. Жанибековын хамтаар 1981 оны гуравдугаар сарын 22-ны өдрийн 14.58 цагт хуучнаар ЗХУ-ын Байконуур дахь сансрын хөлөг хөөргөх талбайгаас "Союз-39" хөлгөөр хөөрсөн. Тэд сансарт нийт найман өдрийн турш дэлхийг 124 удаа тойрч, гуравдугаар сарын 30-нд эх дэлхийдээ амжилттай газардсан аж. Жүгдэрдэмидийн Гуррагчаа сансарт ниссэн Монголоос анхны, Ази тивийн хоёр дахь, дэлхийн 101 дэх хүн хэмээн сансар судлалын түүхэнд бичигдэн үлдсэн билээ.

❖ Энэ баярыг дэлхийн 30-аад улс үндэстэн өргөнөөр тэмдэглэдэг уламжлалтай. Наурызын баяраар ахан дүүс, хотол олноороо учран золгож, ахмадуудаа хүндэтгэхийн ялдамд үр хүүхэд, залуустаа эрхэм сургаалиа хүртээж, үдэж буй оныхоо ажил үйлс, ололт амжилтаа дүгнэдэг.

### Олон улсын эмч нарын өдөр /3 дугаар сарын 30/

Дэлхийн эмч нарын өдрийг анх 1933 оны 3 дугаар сарын 30-ны өдөр АНУ-д тэмдэглэж эхэлсэн түүхтэй. Ерөнхийлөгч Ж.Буш 1990 оны 3 дугаар сарын 30-нд "Үндэсний эмч нарын өдөр" болгон тэмдэглэх болсноос хойш Дэлхийн эмч нарын холбооноос энэ баярыг жил бүр дэлхий даяар албан ёсоор тэмдэглэх өдөр болгон зарлажээ.

## ЭМГЭНЭЛ

#### ДУГАРСҮРЭНГИЙН МЯГМАРСҮРЭН /1975-2021/



Чөлөөнд байсан дэд хурандаа Д.Мягмарсүрэн 2021 оны 2 дугаар сарын 21-ний өдөр өвчний улмаас таалал төгсөж бидэнд хүнд гарз тохиолоо. Тэрбээр 1975 онд Улаанбаатар хотын Налайх дүүрэгт төрж, 1983-1993 онд Налайх дүүргийн 1 дүгээр 10 жил, 1993-1997 онд ЦИС-ийн офицерын сургуулийг Зэвсэг ашиглалтын инженер мэргэжлээр тус тус төгссөн.

Дэд хурандаа Д.Мягмарсүрэн нь ЦИС-ийн офицерын сургууль, Ахлагчийн сургууль, БХИС-ийн Ерөнхий цэргийн тэнхимийн галын бэлтгэлийн багш, ахлах багш, Зэвсэгт хүчний 015 дугаар ангид Галт хэрэглэл хадгалах тасгийн дарга, Зэвсэглэл, галт хэрэглэл хадгалах тусгай төвийн даргын албыг хашсан зэвсгийн мэргэжлийн сурган хүмүүжүүлэгч багш, шилдэг цэргийн дарга нарын нэг байсан юм. Зэвсэг ашиглалтын инженер, ерөнхий цэргийн мэргэжлийн офицер, сурган хүмүүжүүлэгч багш тэрээр Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийг өндөр түвшинд зохион байгуулах, үе үеийн офицер, ахлагч нарт буудлагын зэвсгийн хичээлээр онол дадлагын мэдлэг, ур чадвар олгож үр бүтээлтэй ажиллажээ.

Түүний хөдөлмөр зүтгэлийг төр засгаас өндрөөр үнэлж, Ардын боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэг, Дайчин алдар I, II, III медаль, Цэргийн хүндэт медаль болон бусад ойн медалиар тус тус шагнасан юм.

Таны минь гэгээн дүр, ажилч хичээнгүй, хөдөлмөрч, шударга зан чанар үе үеийн офицер, ахлагч, олон мянган шавь нар, бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно.

**ЗХЖШ-ЫН МАТЕРИАЛ ТЕХНИКИЙН ГАЗРЫН ЗЭВСГИЙН ХЭЛТЭС, ЗЭВСГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХОЛБОО, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 015 ДУГААР АНГИ, ҮБХИС, ГЭР БҮЛ, ҮР ХҮҮХЭД, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, НАЙЗ НӨХӨД НЬ**

## Нурууны өвчнийг мэсгүйгээр анагааж болно

Ихэнх хүн биеэ цэх барьж сураагүй, үргэлж бөгтийж явдгаас нурууны үений мөгөөрс элэгдэж нимгэрдэг. Эсвэл нуруунд хэт их ачаалал үүссэнээс бэртэж гэмтэн, нурууны нугаламууд нэг цэх эгнээнд байрлахаа больж мэдрэлд дарагдан өвдөлт, зовуурь үүсдэг. Бариа заслаар гажсан нурууны ясыг эргүүлээд зөв байрлалд нь оруулж болдог. Мөн физик эмчилгээ, биеийн тамирын дасгал үр дүнтэй аргад тооцогдоно. Эмийн эмчилгээ нь тухайн үедээ өвчин намдаах, булчин суллах үйлчилгээ үзүүлээд өнгөрнө. Хамгийн үр дүнтэй арга бол дасгал хөдөлгөөн. Тухайлбал, нурууны сунгалтын болон булчин чангалах дасгал, мөн явган алхах нь маш тустай. Нурууны нугасны дискүүдийн хооронд байгаа мөгөөрсөн жийргэвчүүд нь мэдрэлийн судас юм. Энэ нь хүний идэвхтэй хөдөлгөөний үр дүнд нэвчих замаар тэжээлээ авдаг. Иймд нуруу нь өвддөг бол өвчин зовууриа хүндрүүлэхгүйн тулд удаан хугацаагаар суух, ууц нуруугаараа даарах, хүнд юм өргөх зэргээс зайлсхийж гам барих нь зүйтэй.

Цэргийн төв эмнэлэг СЗЭТ-ийн сувилагч Т.ОЮУНСҮРЭН



## СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор  
Хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХҮЯГ

Эхийг "Соёмбо" сонины редакцад бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

\*Зар, рекламгыг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл болон сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018

И-мэйл хаяг:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029